



- НЭЭЛТТЭЙ
- ИЛ ТОД
- ШУДАРГА



“МАХНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦОО”

судалгааны тайлан

2022

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн
чөлөө, 18А-1, монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын
үндэсний холбооны байр II давхар

Утас:7012-8779

www.mce.mn

И-Мэйл: info@mce.mn

АГУУЛГА

Удиртгал

Судалгааны үндэслэл

Судалгааны зорилго

Судалгааны зорилтууд

I БҮЛЭГ. Нийлүүлэлтийн сүлжээний тухай онолын үзэл баримтлал

1.1 Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн тухай үндсэн ойлголт

1.2 Нийлүүлэлтийн сүлжээний төрөл, ангилал

II БҮЛЭГ. Махны салбарын өнөөгийн байдал

2.1 Махны салбарын нийлүүлэлтийн тогтолцооны өнгөрсөн болон өнөөгийн байдал

2.2 Монгол улсын махны зах зээлийн нийлүүлэлт

2.3 Монгол улсын мах үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

2.4 Мал аж ахуйн салбарын бодлого, хууль эрх зүйн орчин

2.5 Махны зах зээлд оролцогч талууд, тэдгээрийн оролцоо

III БҮЛЭГ. Махны экспорт, гадаадын биржийн судалгаа

3.1 Махны экспортын судалгаа

3.2 Амьд малын арилжаа

IV БҮЛЭГ Дүгнэлт

1. Судалгааны үндэслэл

Мах, махан бүтээгдэхүүн бол манай хүн амын хүнсний хэрэглээний бүтцэд харьцангуй өндөр хувийн жин эзлэдэг хүнсний гол бүтээгдэхүүн билээ. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос мал аж ахуйн бүтээгдэхүүн түүний дотор махыг хэрэглэгчдэд хүргэх үүргийг гүйцэтгэж байсан мах бэлтгэлийн тогтолцоо задран унаснаар үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн хооронд “хоосон орон зай” үүсч мах борлуулах ажиллагааг завсарын наймаачид буюу “ченж”-үүд гүйцэтгэх болсон юм.

Гэвч ченжүүд махыг ариун цэврийн наад захын шаардлага хангаагүй агуулахад хадгалж, тээвэрлэж байгаагаас гадна эцсийн хэрэглэгчдэд очих хүртлээ мах бөөний болон жижиглэн худалдаачдаар дамжин гарал үүсэл нь тодорхойгүй, эрүүл ахуй, чанарын ямар ч баталгаагүй болж хувирч байгаа ба олон шат дамжсанаар махны жижиглэнгийн үнийг ихээхэн нэмэгдүүлж байна.

Мөн улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн дунджаар 438.5 мян.тн мах бэлтгэсэн. Энэхүү үйлдвэрлэгдсэн нийт махны 5 хүрэхгүй хувийг мал төхөөрөх 68 үйлдвэр, 30 жижиг цех, мах боловсруулах 66 үйлдвэрт бэлтгэж боловсруулсан байна. Энэ нь мал төхөөрөх болон мах боловсруулах хүчин чадлын ашиглалт улсын хэмжээнд хангалтгүй байгааг харуулж байна.

Монголын махны экспортын зах зээлийг өргөжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бараа, түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд мал төхөөрөх газар, мах боловсруулах үйлдвэрүүдийн үр ашиг, бүтээмж, чанарын тогтолцоог сайжруулж, хүнсний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна.

Иймд махны нийлүүлэлтийн одоогийн тогтолцоог судалж, тулгамдаж буй саад бэрхшээлийг тодорхойлон, тэдгээрийг сайжруулах боломж, биржийн арилжаанд хэрхэн оруулах талаар санал боловсруулахад судалгааны зорилго оршино.

2. Судалгааны зорилго

Махны нийлүүлэлтийн одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, шат дамжлагыг бууруулах, сүлжээг боловсронгуй болгох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр гарцыг тодорхойлох, цаашид биржийн арилжаанд оруулахад боломжит хувилбараар санал дэвшүүлнэ.

3. Судалгааны зорилтууд

Дээрхи зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьж байна.

- Монголын мах үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтолцооны талаар тоон мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх;
- Бусад орны махны нийлүүлэлтийн тогтолцооны талаарх туршлага судлах;
- Цаашид махны тогтолцоог сайжруулах боломж, арга замыг тодорхойлон, түүнд үндэслэн санал боловсруулан гаргах.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 1.1. Нийлүүлэлтийн сүлжээний тухай үндсэн ойлголт, үзэл баримтлал
- 1.2. Нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг хариуцлага

1.1. Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн тухай үндсэн ойлголт

Нийлүүлэлтийн сүлжээний менежмент гэсэн нэр томъёог анх 1982 онд Oliver, Webber гэгч 2 зөвлөгч гаргажээ. Нийлүүлэлтийн сүлжээний менежмент гэсэн ойлголтыг гарч ирэхээс өмнө судлаачид нийлүүлэлтийн сүлжээний менежментийн харилцаа холбоо, интеграци нэгдлийн талаар олон судалгаа явуулж байсныг үгүйсгэх аргагүй юм. Гэвч эдгээр судалгаанууд нь маркетинг, зохион байгуулалтын шинжтэй асуудлуудыг шийдвэрлэх, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, түүнийг боловсронгуй болгоход чиглэгдсэн асуудлуудыг судлахад голлон чиглэгдэж байв.

Эдгээр судалгааны үр дүнд дараах ойлголтуудыг судлаачид гаргаж ирсэн байна.

- Сувгийн шинжилгээ судалгаа/AIDERSON 1957/
- Харилцаа ба хамтын ажиллагаа/Bowersox 1969/
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний борлуулалт, тэдгээрийн сүлжээнд тавих хяналт /Hanssmann1959/
- Үйлдвэрлэлийн болон борлуулалтын өсөлтийн систем, түүний нөлөөлөл /Forrester 1958/
- Үйлдвэрлэлийн төлөвлөлт/Haks Mill 1975/


Нийлүүлэлтийн сүлжээ гэдэг нь:

- ❖ Түүхий эдийн үйлдвэрлэлээс эхлэн эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх хүртэлх нийт эдийн засгийн үйл ажиллагааны дэс дараалал
- ❖ Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчээс үйлдвэрүүд болон бөөний төвүүдийг дамжин эцсийн хэрэглэгчид очиж байгаа материал, мэдээлэл, үйлчилгээний урсгал

- ❖ Тухайн нэг бүтээгдэхүүний түүхий эдийг үйлдвэрлэгчид болон боловсруулах үйлдвэрийнхэн, худалдааныхан, эцсийн хэрэглэгчид хүргэж буй бизнесийнхнийг холбон уялдуулж өгсөн нийтээр хүлээн зөвшөөрсөн дүрэм болон хариуцлага, зохион байгуулалт гэх зэргээр тодохойлсон байдаг.

Нийлүүлэлтийн сүлжээ нь мөн эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, мэдээлэл, үйлчилгээг бий болгон хүргэдэг процесс болон байгууллагыг багтаадаг. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааны сүлжээ юм. Энд худалдах, төлбөрийн урсгал, материал боловсруулалт, үйлдвэрлэлийн төлөвлөлт ба хяналт, логистик болон хадгалалт, техник тоног төхөөрөмжийн хяналт хуваарилалт болон хүргэлт зэрэг олон үйл ажиллагааг агуулдаг.

Нийлүүлэлтийн сүлжээг бүдүүвч байдлаар дүрслэвэл:



1-р схем. Нийлүүлэлтийн сүлжээ

Нийлүүлэлтийн сүлжээг бизнес болон цэрэг армид удаан хугацааны туршид хэрэглэж ирсэн ба үр ашгийг нь аль хэдийн мэддэг болсон.

Өнөөгийн өрсөлдөөнтэй бизнесийн орчинд үр ашигтай, нөлөөтэй нийлүүлэлтийн сүлжээтэй байх нь ихэнх байгууллагуудын оршин тогтнох үндэс бөгөөд тэд ихэвчлэн мэдээллийн дэмжлэгээс ихээхэн хамааралтай байдаг.

Нийлүүлэлтийн сүлжээн дэх урсгал:

1. Материалын урсгал
2. Санхүүгийн урсгал
3. Мэдээллийн урсгал

Нийлүүлэлтийн сүлжээний бүрэлдэхүүн:

- Дээш чиглэсэн нийлүүлэлтийн сүлжээ

- Дотоод нийлүүлэлтийн сүлжээ
- Доош чиглэсэн нийлүүлэлтийн сүлжээ

Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн үндсэн функцүүд:

1. Төлөвлөлт
2. Зохион байгуулалт
3. Удирдлага, Манлайлал
4. Хяналт


Эдгээр дөрвөн функц нь тасралтгүй явагдах менежментийн үйл ажиллагаа юм.

Төлөвлөлт нь байгууллагын хүрэх үр дүнг тодорхойлж, зохион байгуулалт нь тодорхой үр дүнд хүрэхийн тулд хэрхэн ажиллахыг тодотгож, хяналт нь гүйцэтгэлийн зохих түвшинд үр өгөөжтэй хүрсэн эсэхийг тодорхойлоход:



1-р зураг. Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн үндсэн функцүүд

Үйл ажиллагааг төлөвлөх үйл явц нарийн дэс дараа, нягт уялдаа холбоотой алхмуудаас бүрддэг.



2-р зураг. Төлөвлөлтийн түвшин

- Стратеги төлөвлөлт нь урт хугацааг хамарсан, харьцангуй ерөнхий, өргөн хүрээтэй төлөвлөлтийн төрөл.
- Тактикийн төлөвлөлт дунд хугацааг хамарсан, харьцангуй тодорхой асуудалд төвлөрсөн төлөвлөлтийн хэлбэр юм. Стратеги төлөвлөлтийн үр дүнд хүрэх алхмуудыг дунд хугацааны болон бизнесийн зэрэг илүү тодорхой төлөвлөгөөнүүдээр нарийвчлан тодорхойлдог.
- Үйл ажиллагааны төлөвлөлт нь тодорхой асуудалд төвлөрсөн, 1 жил хүртэл хугацааг хамарсан, төлөвлөлтийн төрөл.

Стратеги, тактикийн төлөвлөлтийн үр дүнг тодорхой алхмууд, тодорхой тоон үзүүлэлтүүд, богино хугацааны хэмжигдэхүйц зорилгуудаар илэрхийлдэг. Тактикийн төлөвлөсөн үр дүнд хүрэх алхмуудыг нарийвчлан тодорхойлдог.

Нийлүүлэлтийн сүлжээний менежментийг стратегийн түвшний буюу дээд шатны удирдлагууд төлөвлөдөг байна.

Нийлүүлэлтийн сүлжээний удирдлага гэж юу вэ?

- Нийлүүлэлтийн сүлжээний бүх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уялдуулан зохицуулах ажиллагаа.
- Нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын гол зорилго нь өндөр чанартай бүтээгдэхүүнийг зөв хэрэглэгчид нь зөв цагт нь хамгийн бага зардалтай хүргэх юм.

- Орчин үеийн нийлүүлэлтийн нэгжээний удирдлагын гол зорилго нь тодорхойгүй байдал, эрсдэлийг багасгаж, тоног төхөөрөмжийн түвшин, циклийн хугацаа, бизнесийн процесс, хэрэглэгчдийн үйлчилгээ зэрэгт эерэгээр нөлөөлөх юм.

Нийлүүлэлтийн сүлжээний удирдлагыг хэрэгжүүлснээр:

- Хугацаа, хөрөнгө оруулалтын зардлыг багасгадаг
- Материалын хангамж, түүхий эд материалыг дундаж эсвэл эцсийн бүтээгдэхүүн болгоход тусалдаг
- Эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэх түгээлтийн ажилд тусалдаг
- Хэрэглэгчээс буцаагдаж ирсэн барааны логистикийн асуудлыг ч багтаасан байдаг

Нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын систем:

Нийлүүлэлтийн сүлжээний богино сегментүүдийг дэмжсэн анхны програм хангамжууд 1950, 1960-аад оны эхээр гарч ирсэн.

Нийлүүлэлтийн сүлжээний тодорхой сегментийг дэмжих, ялангуяа үйлдвэрийн тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, ажилын ажиллах цагийн хуваарь гаргах, тээвэрлэлт зэргийг дэмждэг програм хангамж юм.

SCM систем нь байгууллагын нөөцийн төлөвлөлтийн системийг ухаалаг шийдвэр гаргалт болон бизнесийн чадваруудаар хангахын тулд гарч ирсэн нэмэлт иж бүрдэл юм.

Нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын системийн зорилго:

- ◦ Зардалыг багасгах
- ◦ Үйл явцыг түргэтгэх
- ◦ Алдаа бага гаргах
- ◦ Өргөн хүрээнд харах боломж олгох
- ◦ Дурын газраас боломжтой бүх өгөгдөлд хандах боломжийг олгох юм.

Нийлүүлэлтийн сүлжээний менежментэд тулгарч буй бэрхшээлүүд, тэдгээрийг шийдэх шийдлүүд:

Тодорхойгүй байдал:

- ✓ Эрэлт хэрэгцээг таамаглах
- ✓ Илгээх цаг хугацаа болон үйлдвэрлэлийн саатал зэрэг бэрхшээл нь тодорхойгүй байдлаас үүсэн гарч ирж байна.

Муу зохицуулалт:

- ✓ Дотоод нэгж болон бизнесийн түншүүдтэйгээ муу харьцаатай байх
- ✓ Хэрэглэгчдэд үр нөлөөгүй үйлчилгээ үзүүлэх
- ✓ Хөрөнгө оруулалтын өндөр зардал, нөхөн төлөгдөлт байхгүй байх

- ✓ Үйлчилгээ үзүүлэх зардал өснө
- ✓ Нөөцийн илүүдэл зэрэг бэрхшээлүүд нь зохицуулалт муу байгаагаас гарч байгаа юм.

Харин эдгээрийг дараах аргаар шийдвэрлэж болно. Үүнд:

- Шаардлагатай бол нөөцийг “худалдан авах” нь “бий болгох”-оос илүү тохиромжтой байж болно
- Илгээх зохистой төлөвлөгөө гаргах.
- Худалдан авахдаа “яг цагт нь” хандлагыг ашиглах
- Цөөн тооны нийлүүлэгчийг ашиглах
- Захиалгыг хүлээн авсны дараа үйлдвэрлэх
- Нийлүүлэгчтэй нягт хамтран ажилласнаар эрэлт хэрэгцээг зөв таамаглах



1.2. Нийлүүлэлтийн сүлжээний төрөл, ангилал

Нийлүүлэлтийн сүлжээний 4 төрөл байдаг. Тэдгээр нь бие биенээсээ ялгагдах онцлог давуу талууд байна.

Ангилал	Онцлог шинжүүд
Худалдан авалтын төрөл	<ul style="list-style-type: none"> - Худалдан авалтын хэмжээ - Нийлүүлэгчийн уян хатан байдал - Цаг хугацаа - Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг
Үйлдвэрлэлийн төрөл	<ul style="list-style-type: none"> - Бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцын зохион байгуулалт - Мэргэжлийн байдал

	<ul style="list-style-type: none"> - Өөрчлөгдөх чанар - Үйлдвэрлэлийн саад тотгор - Ажлын цагийн уян хатан байдал
Түгээлтийн төрөл	<ul style="list-style-type: none"> - Түгээлтийн бүтэц - Хүргэлтийн хэв маяг - Тээвэрлэлт ачилтын хориг хязгаарлалт
Үнийн төрөл	<ul style="list-style-type: none"> - Хэрэглэгчидтэй холбогдох харьцаа - Эрэлтийн муруй - Бүтээгдэхүүний амьдралын орчил - Бараа материалын тооцоо


Худалдан авалтын төрөл нь худалдан авалтын хэмжээ, нийлүүлэгчийн уян хатан байдал, цаг хугацаа, бүтээгдэхүүний амьдралын мөчлөг, худалдаалагдаж байгаа бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, стандартаар тодорхойлогдоно¹. Бараа бүтээгдэхүүний чанар, онцлог шинж нь бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх процесст бий болно. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн хүрээнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ямар технологи, ямар тоног төхөөрөмж хэрэглэв гэдгээс үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанар, стандарт шалтгаална. Бараа бүтээгдэхүүнүүдийн чанар стандартыг сайжруулж түүний бусдаас ялгагдахуйц онцлог шинжтэй үйлдвэрлэхийн тулд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх техник, технологийг боловсронгуй болгоход илүү их анхаарал тавих шаардлагатай. Худалдан авалтын төрөл нь дараах мэдэгдэх дэд эх үүсвэрүүдээс бүрддэг.



ХОЁРДУГААР БҮЛЭГ. МАХНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Махны салбарын нийлүүлэлтийн тогтолцооны өнгөрсөн болон өнөөгийн байдал

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн /1990 оноос өмнөх/ мах бэлтгэлийн систем



Энэ үед өмчийн нэг хэлбэр ноёрхож байснаас махыг төр, засгаас нарийн зохион байгуулалттайгаар төлөвлөгөөний дагуу бэлтгэн нийлүүлдэг байсан байна.


Ийм учраас мах дайвар бүтээгдэхүүнийг анхан шатны боловсруулалт хийх болон агуулах, тээврийг нэгдсэн зохион байгуулалттайгаар хангадаг байсан байна.

№	Үзүүлэлт	Давуу тал	Сул тал
1	Мах бэлтгэлийн систем	-Мах бэлтгэл нь төвлөрсөн нэгдсэн нэг системтэй байсан бөгөөд орон нутагт сум бүрт худалдаа бэлтгэлийн анги, баг бүрд агенттай байсан.	-Захиргаадалтын арга барилтай байсан. -Мах бэлтгэлийн практикт шинэ техник технологи нэвтрэх боломж хомс байсан. - Төрөөс тогтоосон /Орос улсаас хараат/ нэг үнэ үйлчилдэг байв. - Өрхийн хэмжээнд хувийн мал сүргийн тоог хязгаарладаг байсан учир амин хувьдаа махыг ашиглаж илүү гарсныг төвлөрсөн хэрэгцээнд зах зээлийн үнээр нийлүүлэх боломжгүй байсан.
2	Анхан шатны боловсруулалт	- Орон нутагт бойны цэг дээр малыг нядлан, дайвар бүтээгдэхүүнүүдэд анхан шатны боловсруулалт хийдэг байсан.	- Нэг доор төвлөрүүлэн анхан шатны боловсруулалтанд оруулдаг байсан нь агуулах савны багтаамж болоод хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй байснаас үүдэн түүхий эд бүтээгдэхүүний чанар алдагдах, муудах эрсдлийг дагуулж байсан.
3	Агуулахын аж ахуй	- Агуулахын аж ахуй төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед нийтдээ 18 аймаг, 300 гаруй сумд түүхий эд бүтээгдэхүүний агуулахтай байсан.	- Техник технологи нь ганц улсаас хараат байв.
4	Тээвэрлэлт	- Түүхий эд бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ авто баазаар дамжин түүхий эд бүтээгдэхүүнийг үйлдвэрүүдэд тээвэрлэж хүргэдэг байсан бөгөөд аймгуудад ачаа тээвэрлэлтийн биеэ даасан авто баазууд ажиллаж байв. - Сул гүйлт аль болох байхгүй байхаар тээвэрлэлтийг зохион байгуулдаг байв.	- Зөвхөн Орос улсын авто машинуудыг ачаа тээвэрт ашиглагддаг байв. - Малыг хөлөөр нь тууварлан экспортод гарган хямд үнээр худалдаалдаг байсан.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн /1990 оноос өмнөх/ мах бэлтгэлийн давуу болон сул талуудыг харьцуулан харахад системийн хувьд захиргаадалтын арга барилтай, түүхий эд бүтээгдэхүүн бэлтгэлийн практикт шинэ техник технологи нэвтрэх боломж хомс, хувийн мал сүргийн тоог хязгаарладаг байсан учир амин хувьдаа махыг

ашиглаж илүү гарсныг төвлөрсөн хэрэгцээнд зах зээлд нийлүүлэх боломжгүй, мах махан бүтээгдэхүүнүүдэд Төрөөс тогтоосон нэг үнэ үйлчилдэг байсан зэрэг олон сул талтай байв.

Одоогийн зах зээлийн мах бэлтгэлийн систем



Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос мал аж ахуйн бүтээгдэхүүн түүний дотор махыг хэрэглэгчдэд хүргэх үүргийг гүйцэтгэж байсан мах бэлтгэлийн тогтолцоо задран унаснаар үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн хооронд “хоосон орон зай” үүсч мах борлуулах ажиллагааг завсарын наймаачид буюу “ченж”-үүд гүйцэтгэх болсон байна. Гэвч ченжүүд махыг ариун цэврийн наад захын шаардлага хангаагаагүй саванд хадгалж, тээвэрлэж байгаагаас гадна эцсийн хэрэглэгчидэд очих хүртлээ мах

бөөний болон жижиглэн худалдаачдаар дамжин гарал үүсэл нь тодорхойгүй, эрүүл ахуй, ариун цэврийн ямар ч баталгаагүй бүтээгдэхүүн болж хувирч байна.

S-Давуу тал	W-Сул тал
<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн оролцоогүйгээр зохицуулагдаж байна. ✓ Хувийн хэвшлийн мах бэлтгэлийн аж ахуйн нэгжүүд байна. ✓ Стандартын шаардлага хангасан хувийн хэвшлийн агуулахууд бий болж байна. 	<ul style="list-style-type: none"> ✓ Мах бэлтгэлийн нэгдсэн тогтолцоо байхгүй. ✓ Экспортод гаргаж байгаа мах нь чанар, стандартын шаардлагаас хамаарч хямд үнээр гарч байна. ✓ Малчдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалалын нөхцөл бүрдээгүй . ✓ Гарал үүсэл нь тодорхойгүй, чанарыг баталгаажуулаагүй мах зах зээлд нийлүүлэгдэж байна. ✓ Махны нийлүүлэлтийн бодлого, зохицуулалтгүйгээс Үндэсний үйлдвэрүүд түүхий эдээр дутагддаг. ✓ Зах зээлийн бодит мэдээлэл хангалтгүй. ✓ Махны үнийн хэлбэлзлэл их, үнэ тогтворгүй. ✓ Зориулалтын агуулахын хүрэлцээ маш дутмаг. ✓ Тээвэрлэлтийн нэгдсэн зохицуулалтгүй учраас нэмэгдэл зардал ихтэй. ✓ Завсрын наймаачид буюу ченжүүд хувийн тээвэрлэлтийг хариуцдаг учраас сөрөг тээвэр ихтэй. ✓ Сул гүйлт маш их байдаг. ✓ Тээвэрлэлтийн нөхцөл чанарын шаардлага хангадаггүй. ✓ Ариун цэвэр болоод чанарын шаардлага хангаагүй мах нийлүүлэгддэг.
O-Боломж	T-Аюул занал
<ul style="list-style-type: none"> ✓ Өмчийн олон хэлбэр бий болж мал сүрэг хувьд шилжиж, өөрсдийнхөө ахуйн хэрэглээг бүрэн хангах боломжтой болсон төдийгүй илүү үйлдвэрлэсэн түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд тохиролцсон үнээр нийлүүлэх боломжтой болсон. 	<ul style="list-style-type: none"> ✓ Байгаль цаг уурын тааламжгүй нөлөөлөл. ✓ Эрүүл ахуйн шаардлага хангаагүй мах нийлүүлэгдэж хүн амын эрүүл мэндэд муу нөлөө үзүүлэх аюултай. ✓ Экспорт улам буурах магадлалтай.

<ul style="list-style-type: none"> ✓ Стандартад нийцсэн агуулахуудыг барьж байгуулах нөхцөл боломжууд бүрэн бүрдсэн. ✓ Сүүлийн үеийн авто тээвэрлэлтийг нэвтрүүлэх бүрэн боломжтой. ✓ Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог цэгцлэх эрх зүйн орчин бүрдсэн. ✓ Малын гарал үүслийг баталгаажуулах ажил хийгдэж байгаа. ✓ Хүнсний тухай хуулийг шинэчлэн найруулж баталснаар үндэсний үйлдвэрүүдэд махыг бэлтгэн нийлүүлсэн тохиолдолд урамшуулал олгох тухай шийдвэрлэсэн. 	
--	--

2.2. Монгол улсын махны зах зээлийн нийлүүлэлт

2.2.1. Махны нөөцийн судалгаа

МАЛЫН ТӨРЛӨӨР МАХНЫ ГАРЦ, НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

Адуу

2020 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 4,093.861 толгой адуу тоологдсоноос 2,544,927 толгой адуу нь шүдлэн болон түүнээс дээш насны ангилалд тоологдсон бөгөөд ашиг шимийн гарцыг тооцов. Энэ нь адуун сүргийн 62 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл үлдсэн 38 хувь болох “энэ жилийн төл”, “өнгөрсөн жилийн төл”, “2 настай” ангиллын адуунаас ашиг шим тооцоогүй болно.

Нийт 6 төрлийн баталгаажсан үүлдэр омог бүртгэгдсэн бөгөөд 21 аймаг болон Улаанбаатар хотын хэмжээнд:

№	Аймаг	Монгол үүлдэр	Галшар үүлдэр	Тэс үүлдэр	Дархад омог	Мягад омог	Өндөршил омог	Нийт
1	Архангай	222,371	23					222,394
2	Баян-Өлгий	61,064						61,064
3	Баянхонгор	102,923						102,923
4	Булган	151,983	7					151,990
5	Говь-Алтай	84,802						84,802
6	Говьсүмбэр	12,424						12,424
7	Дархан	10,045	1,180	391				11,616
8	Дорноговь	93,643						93,643
9	Дорнод	115,401	46					115,447
10	Дундговь	95,307					6,836	102,143
11	Завхан	111,819	337	27,567	40	45		139,808
12	Орхон	7,481						7,481
13	Өмнөговь	65,346						65,346
14	Өвөрхангай	172,402	1,117	310				173,829

15	Сүхбаатар	212,479						212,479
16	Сэлэнгэ	105,474	2,314	793	46			108,627
17	Төв	203,673	1,711	105				205,489
18	Увс	61,773		24,095				85,868
19	Ховд	75,989				7,060		83,049
20	Хөвсгөл	168,962		22,045		35,957		226,964
21	Хэнтий	205,502	14,656					220,158
22	Улаанбаатар хот	57,283	80	20				57,383
	Нийт	2,398,146	21,471	75,326	86	43,062	6,836	2,544,927

Монгол үүлдрийн адуу нь нийт үүлдэр омгийн 94 хувийг эзэлж буй бөгөөд бусад 6 хувийг эзлэх үүлдэр омгийн тоог диаграммаар харуулбал:



АДУУНЫ МАХНЫ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

№	Аймаг	Амьдын жин /кг/	Махны гарц /кг/
1	Архангай	63,725,581	27,338,274
2	Баян-Өлгий	16,943,710	7,268,852
3	Баянхонгор	29,641,695	12,716,287
4	Булган	42,405,899	18,192,131
5	Говь-Алтай	24,566,785	10,539,151
6	Говьсүмбэр	3,564,340	1,529,102
7	Дархан	3,214,163	1,378,876
8	Дорноговь	26,988,745	11,578,172
9	Дорнод	32,728,344	14,040,460
10	Дундговь	29,571,847	12,686,322
11	Завхан	39,842,380	17,092,381
12	Орхон	2,144,340	919,922
13	Өмнөговь	18,780,255	8,056,729
14	Өвөрхангай	49,707,500	21,324,518
15	Сүхбаатар	60,721,280	26,049,429

16	Сэлэнгэ	30,106,600	12,915,731
17	Төв	58,991,260	25,307,251
18	Увс	25,813,790	11,074,116
19	Ховд	24,401,160	10,468,098
20	Хөвсгөл	65,732,190	28,199,110
21	Хэнтий	63,494,535	27,239,156
22	Улаанбаатар хот	15,814,816	6,784,556
	Нийт	728,901,215	312,698,621

Тэмээ

2020 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 472.934 тоо толгой тэмээ тоологдсоноос 308.653 толгой нь 3 наснаас дээш ангилалд тоологдсон бөгөөд ашиг шимийн гарцыг тооцов. Энэ нь нийт тэмээн сүргийн 65 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл үлдсэн 35 хувь болох “энэ жилийн төл”, “өнгөрсөн жилийн төл”, “2 настай” ангиллын тэмээнээс ашиг шим тооцоогүй болно.

Нийт 6 төрлийн баталгаажсан үүлдэр омог бүртгэгдсэн бөгөөд 21 аймаг болон Улаанбаатар хотын хэмжээнд:

№	Аймаг	Монгол үүлдэр	Төхөм тунгалагийн хүрэн үүлдэр	Ханын хэцийн хүрэн үүлдэр	Галбын говийн улаан үүлдэр	Ламын гэгээний улаан үржлийн хэсэг	Олдохын хүрэн бор омог	Нийт
1	Архангай	580						580
2	Баян-Өлгий	4,124						4,124
3	Баянхонгор	26,132				16,253		42,385
4	Булган	753						753
5	Говь-Алтай	16,548	13,590					30,138
6	Говьсүмбэр	677						677
7	Дархан	44						44
8	Дорноговь	27,637						27,637
9	Дорнод	2,333						2,333
10	Дундговь						4,269	4,269
11	Завхан	5,616			5			5,621
12	Орхон	34						34
13	Өмнөговь	80,129		25,742	13,317			119,188

14	Өвөрхангай	17,820		2,068	145			20,033
15	Сүхбаатар	5,500						5,500
16	Сэлэнгэ	429						429
17	Төв	2,504		8	24			2,536
18	Увс	16,878						16,878
19	Ховд	17,859						17,859
20	Хөвсгөл	1,658						1,658
21	Хэнтий	3,001						3,001
22	Улаанбаатар хот	245						245
	Нийт	230,501	13,590	27,818	13,491	16,253	4,269	305,922

Монгол үүлдрийн тэмээ нь нийт үүлдэр омгийн 75 хувийг эзэлж буй бөгөөд бусад 5 хувийг эзлэх үүлдэр омгийн тоог диаграммаар харуулбал:



ТЭМЭЭНИЙ МАХНЫ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

№	Аймаг	Амьдын жин /кг/	Махны гарц /кг/
1	Архангай	332,880	165,774
2	Баян-Өлгий	2,340,310	1,165,474
3	Баянхонгор	23,772,122	11,838,517
4	Булган	409,726	204,044
5	Говь-Алтай	12,149,903	6,050,652
6	Говьсүмбэр	374,038	186,271
7	Дархан	24,048	11,976
8	Дорноговь	15,327,131	7,632,911
9	Дорнод	1,394,920	694,670
10	Дундговь	14,065,776	7,004,756
11	Завхан	2,944,954	1,466,587
12	Орхон	18,387	9,157
13	Өмнөговь	60,268,764	30,013,844
14	Өвөрхангай	10,281,806	5,120,339
15	Сүхбаатар	2,959,683	1,473,922
16	Сэлэнгэ	226,512	112,803
17	Төв	1,359,949	677,255
18	Увс	9,047,186	4,505,499
19	Ховд	9,456,790	4,709,481
20	Хөвсгөл	874,601	435,551
21	Хэнтий	1,615,827	804,682
22	Улаанбаатар хот	129,360	64,421
	Нийт	169,374,673	84,348,587

Үхэр


2020 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 4.732.010 тоо толгой үхэр тоологдсоноос 2.843.156 толгой үхэр нь нас бие гүйцсэн ангилалд тоологдсон бөгөөд ашиг шимийн гарцыг тооцов. Энэ нь нийт үхэр сүргийн 60 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл үлдсэн 40 хувь болох “энэ жилийн төл”, “өнгөрсөн жилийн төл” ангиллын үхрээс ашиг шим тооцоогүй болно.

Нийт 5 төрлийн баталгаажсан үүлдэр омог бүртгэгдсэн бөгөөд 21 аймаг болон Улаанбаатар хотын хэмжээнд:

№	Аймаг	Монгол үүлдэр	Монгол үүлдрийн сарлаг	Сэлэнгэ үүлдэр	Дорнод Монголын улаан үүлдэр	Буган халиун үүлдрийн хэсэг	Нийт
1	Архангай	386,559	21	78			386,658
2	Баян-Өлгий	86,709					86,709
3	Баянхонгор	138,503					138,503
4	Булган	135,237	37	8,464			143,738
5	Говь-Алтай	44,852		18			44,870
6	Говьсүмбэр	8,299		6			8,305
7	Дархан	23,338		1,899			25,237
8	Дорноговь	52,081					52,081
9	Дорнод	205,245		21	10,954		216,220

10	Дундговь	41,304					41,304
11	Завхан	112,678	10,745	146			123,569
12	Орхон	10,567					10,567
13	Өмнөговь	18,143					18,143
14	Өвөрхангай	143,557	30	728	80		144,395
15	Сүхбаатар	154,087			44,373		198,460
16	Сэлэнгэ	181,760		41,487	30		223,277
17	Төв	128,070	140	422	2	14,170	142,804
18	Увс	113,781					113,781
19	Ховд	107,285					107,285
20	Хөвсгөл	138,394	131,651				270,045
21	Хэнтий	266,888		28			266,916
22	Улаанбаатар хот	80,168	16	17	88		80,289
	Нийт	2,591,675	142,640	53,314	55,527	-	2,843,156

Монгол үүлдрийн үхэр нь нийт үүлдэр омгийн 91 хувийг эзэлж буй бөгөөд бусад 9 хувийг эзлэх үүлдэр омгийн тоог диаграммаар харуулбал:



ҮХРИЙН МАХНЫ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

№	Аймаг	Амьдын жин /кг/	Махны гарц /кг/
1	Архангай	92,340,448	43,861,713
2	Баян-Өлгий	20,626,878	9,797,767
3	Баянхонгор	33,006,374	15,678,028
4	Булган	35,311,474	16,772,950
5	Говь-Алтай	10,711,422	5,087,925
6	Говьсүмбэр	1,953,734	928,024
7	Дархан	6,178,224	2,934,656
8	Дорноговь	12,312,896	5,848,626
9	Дорнод	53,449,412	25,388,471
10	Дундговь	9,755,796	4,634,003
11	Завхан	29,943,384	14,223,107
12	Орхон	2,485,002	1,180,376
13	Өмнөговь	4,405,838	2,092,773
14	Өвөрхангай	35,515,478	16,869,852
15	Сүхбаатар	51,114,526	24,279,400
16	Сэлэнгэ	63,624,912	30,221,833
17	Төв	34,464,592	16,370,681
18	Увс	27,605,254	13,112,496
19	Ховд	26,440,112	12,559,053
20	Хөвсгөл	77,204,366	36,672,074
21	Хэнтий	66,276,832	31,481,495
22	Улаанбаатар хот	20,419,852	9,699,430
	Нийт	715,146,806	339,694,733


Ямаа

2020 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 27.720.253 тоо толгой ямаа тоологдсоноос 21.161.753 толгой нь борлон болон түүнээс дээш насны ангилалд тоологдсон бөгөөд ашиг шимийн гарцыг тооцов. Энэ нь ямаан сүргийн 76 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл үлдсэн 24 хувь болох “энэ жилийн төл” ангиллын ямаанаас ашиг шим тооцоогүй болно.

Нийт 13 төрлийн баталгаажсан үүлдэр омог бүртгэгдсэн бөгөөд 21 аймаг болон Улаанбаатар хотын хэмжээнд:

№	Аймаг	Монгол үүлдэр	Говь гурван сайхан үүлдэр	Уулын бор үүлдэр	Завхан буурал үүлдэр	Залаа жинст эдрэн үүлдэр	Алтайн улаан үүлдэр	Баяндэлгэр ийн улаан үүлдэр	Өлгийн улаан үүлдэр	Эрчимийн хар үүлдэр	Бөмбөгер ийн улаан омог	Өнжүүл үржлийн хэсэг	Галшарын улаан омог	Дэлгэрэхий н улаан омог	
1	Архангай	1,160,453			50				23	280					1,160,806
2	Баян-Өлгий	42		668,283											668,325
3	Баянхонгор	1,315,736				186,153					131,655				1,633,544
4	Булган	831,264		2					110	250					831,626
5	Говь-Алтай	1,543,956					35,098								1,579,054
6	Говьсүмбэр	140,003			1,222	416		1,483							143,124
7	Дархан	59,564		4,053	70	254	207	142	21,738	3,616					89,644
8	Дорноговь	841,221												13,160	854,381
9	Дорнод	399,302						11,333							410,635
10	Дундговь	1,288,487													1,288,487
11	Завхан	794,074			180,729	103				101					975,007
12	Орхон	37,499													37,499
13	Өмнөговь	1,494,025	25,345												1,519,370
14	Өвөрхангай	1,412,443	31,213	1,363		1,485		36,544	580	926		386			1,484,940
15	Сүхбаатар	425,241						854,998							1,280,239
16	Сэлэнгэ	623,155		1,521	1,294	252	2,503	16,975	18,793	3,908	521			90	669,012
17	Төв	1,187,415			160	483		3,950	350	466	90	102			1,193,016
18	Увс	702,319							294,033						996,352
19	Ховд	1,168,425					88,951								1,257,376
20	Хөвсгөл	1,508,075								174,390					1,682,465
21	Хэнтий	1,176,958											83,466		1,260,424
22	Улаанбаатар хот	145,345						325		308		449			146,427
	Нийт	18,255,002	56,558	675,222	183,525	189,146	126,759	925,750	335,627	184,245	132,266	937	83,466	13,250	21,161,753

Монгол үүлдрийн ямаа нь нийт үүлдэр омгийн 86 хувийг эзэлж буй бөгөөд бусад 14 хувийг эзлэх үүлдэр омгийн тоог диаграммаар харуулбал:



ЯМААНЫ МАХНЫ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

№	Аймаг	Амьдын жин /кг/	Махны гарц /кг/	Ноолуурын гарц /кг/
1	Архангай	38,875,124	14,772,547	264,629
2	Баян-Өлгий	29,234,766	11,109,211	311,441
3	Баянхонгор	53,681,006	20,398,782	392,598
4	Булган	29,203,181	11,097,209	194,441
5	Говь-Алтай	52,302,739	19,875,041	350,300
6	Говьсүмбэр	4,847,743	1,842,142	33,463
7	Дархан	3,152,680	1,198,018	23,998
8	Дорноговь	28,626,766	10,878,171	195,666
9	Дорнод	14,575,223	5,538,585	102,284
10	Дундговь	43,078,538	16,369,844	292,880
11	Завхан	32,689,004	12,421,821	262,972
12	Орхон	1,270,086	482,633	8,700
13	Өмнөговь	52,804,240	20,065,611	346,921
14	Өвөрхангай	51,886,483	19,716,864	350,465
15	Сүхбаатар	38,141,856	14,493,905	341,215
16	Сэлэнгэ	23,165,908	8,803,045	154,284
17	Төв	41,943,922	15,938,690	280,031
18	Увс	36,070,726	13,706,876	258,359
19	Ховд	44,539,287	16,924,929	306,020
20	Хөвсгөл	57,827,378	21,974,404	392,904

21	Хэнтий	44,870,769	17,050,892	315,260
22	Улаанбаатар хот	4,980,117	1,892,444	33,535
	Нийт	727,767,540	276,551,665	5,212,366

Хонь

2020 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 30.049.428 толгой хонь тоологдсоноос 20.712.341 хонь нь төлөг болон түүнээс дээш насны ангилалд тоологдсон бөгөөд ашиг шимийн гарцыг тооцов. Энэ нь нийт хонин сүргийн 69 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл үлдсэн 31 хувь болох “энэ жилийн төл” ангиллын хониноос ашиг шим тооцоогүй болно. Нийт 26 төрлийн баталгаажсан үүлдэр омог бүртгэгдсэн бөгөөд 21 аймаг болон Улаанбаатар хотын хэмжээнд:

№	Аймаг	Монгол үүлдэр	Барга үүлдэр	Үзэмчин үүлдэр	Керей үүлдэр	Байдраг үүлдэр	Баяд үүлдэр	Хотонт үржлийн хэсэг	Цагаан-Уул үүлдэр	Баянгол омог	Тамир үүлдэр	Баянбулаг омог	Тал нутгийн цагаан	Сүмбэр үүлдэр	Дархад үүл дэр
1	Архангай	1,969,465		69			4,052	15,57 5	3,562	210	8,201				
2	Баян- Өлгий	5,042			668,68 1		70,282								
3	Баянхонго р	703,239				48,149						33,74 6			
4	Булган	1,227,614	5				1,368		13				2	1	79
5	Говь-Алтай	628,381													
6	Говьсүмбэ р	140,408	4,518	3,806										1,366	
7	Дархан	62,029	110	405	8,568		31,645			523					
8	Дорноговь	709,133													
9	Дорнод	375,362	104,71 7	94,983											
10	Дундговь	1,127,350													
11	Завхан	552,548	905	63			331	98		8					
12	Орхон	35,049													
13	Өмнөговь	504,703													
14	Өвөрханга й	1,396,129	30,846	7,823	151		2,437	1,702		147,5 51		-			
15	Сүхбаатар	476,813		825,82 7											
16	Сэлэнгэ	613,820	4,039	10,302	6,690	300	128,748	772		15					210
17	Төв	1,714,948	6,795	546			7,584		654				2		
18	Увс	624,007					458,178								
19	Ховд	634,677													
20	Хөвсгөл	583,794							426,16 2						482,5 14
21	Хэнтий	1,686,502											506		
22	Улаанбаат ар хот	174,193	493			10	2		6						
	Нийт	15,945,206	152,42 8	943,82 4	684,09 0	48,459	704,627	18,14 7	430,39 7	148,3 07	8,201	33,74 6	510	1,367	482,8 03

№	Аймаг	Говь-Алтай үүлдэр	Ерөө үүлдэр	Торгууд үүлдрийн хэсэг	Буриад омог	Сайнцагаан омог	Орхон үүлдэр	Хангай үүлдэр	Сартуул үүлдэр	Сутай үүлдэр	Алтанбулаг уржлийнхэсэг	Нийт
1	Архангай											2,001,134
2	Баян-Өлгий											744,005
3	Баянхонгор											785,134
4	Булган	2										1,229,084
5	Говь-Алтай	34,480										662,861
6	Говьсүмбэр											150,098
7	Дархан	256	184	190								103,910
8	Дорноговь											709,133
9	Дорнод				108,44 9							683,511
10	Дундговь					131,603						1,258,953
11	Завхан	751					54	32	692,464			1,247,254
12	Орхон											35,049
13	Өмнөговь											504,703
14	Өвөрхангай						119					1,586,758
15	Сүхбаатар											1,302,640
16	Сэлэнгэ		3,908				7,436	5,740	827		200	783,007
17	Төв					502	200		70		100	1,731,401
18	Увс											1,082,185
19	Ховд			43,086						79,384		757,147
20	Хөвсгөл											1,492,470
21	Хэнтий											1,687,008
22	Улаанбаатар хот	192										174,896
	Нийт	35,681	4,092	43,276	108,44 9	132,105	7,809	5,772	693,361	79,384	300	20,712,341

ХОНИНЫ МАХНЫ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

№	Аймаг	Амьдын жин /кг/	Махны гарц /кг/	Ноосны гарц /кг/
1	Архангай	88,500,766	37,170,322	2,787,714
2	Баян-Өлгий	38,219,156	16,052,045	1,023,897
3	Баянхонгор	34,822,511	14,625,455	1,106,836
4	Булган	71,025,360	29,830,651	2,035,841
5	Говь-Алтай	29,081,356	12,214,170	940,909
6	Говьсүмбэр	6,850,051	2,877,021	212,385
7	Дархан	4,977,247	2,090,444	156,585
8	Дорноговь	31,479,552	13,221,412	999,197
9	Дорнод	35,798,901	15,035,538	956,339
10	Дундговь	55,053,856	23,122,620	1,783,961
11	Завхан	56,387,957	23,682,942	1,728,106
12	Орхон	1,566,642	657,990	49,656
13	Өмнөговь	23,076,321	9,692,055	703,147
14	Өвөрхангай	73,971,738	31,068,130	2,253,473
15	Сүхбаатар	69,764,595	29,301,130	1,714,615
16	Сэлэнгэ	32,833,530	13,790,083	1,083,259
17	Төв	79,241,498	33,281,429	2,435,456
18	Увс	51,870,360	21,785,551	1,655,001
19	Ховд	36,113,974	15,167,869	1,112,313
20	Хөвсгөл	75,681,459	31,786,213	2,207,204
21	Хэнтий	77,439,930	32,524,771	2,385,850
22	Улаанбаатар хот	7,760,372	3,259,356	236,448
	Нийт	981,517,131	412,237,195	29,568,192

Монгол үүлдрийн хонь нь нийт үүлдэр омгийн 77 хувийг эзэлж буй бөгөөд бусад 23 хувийг эзлэх үүлдэр омгийн тоог диаграммаар харуулбал:



3. НИЙТ МАХНЫ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

	Мах /кг/
Адуу	312,698,621
Тэмээ	84,348,587
Үхэр	339,694,733
Ямаа	276,551,665
Хонь	412,237,195
Нийт	<u>1,425,530,801</u>

Энэхүү судалгаанд 2020 оны эцсийн байдлаарх нийт малын 70,9 хувийг ашиг шим өгөх, нөөцөд тооцогдох малаар тооцож үр дүнг гаргав. Өөрөөр хэлбэл адуу, тэмээнд 3 наснаас доош, үхэрт “энэ жилийн төл”, хонь, ямаанд “энэ жилийн төл”, “өнгөрсөн жилийн төл”-ийг тус тус тооцоонд оруулаагүй болно.


2.2.2. Бэлчээрийн даацын асуудал

1. МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, БЭЛЧЭЭРИЙН ДААЦ

Махны нийлүүлэлт, чанарын асуудлыг ярихад юуны түрүүн малын бэлчээр, бэлчээрийн хүрэлцээ, бэлчээрийн даацын асуудал хөндөгдөнө. Эрүүл, хүрэлцээтэй, үржил шимт ургамлаар баялаг бэлчээрээс эрүүл мах гарна. Мөн эсрэгээрээ бэлчээрийн доройтлыг бууруулахад махны нийлүүлэлт нөлөөлж чадна. Өөрөөр хэлбэл бэлчээрээ зохистой ашигладаг хариуцлагатай малчнаас, хоршооноос махны нийлүүлэлтийг хийнэ гэсэн хандлага суулгаж өгөх.


Бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлоход тухайн жилийн бэлчээрийн бүтээмж, ургамлын хувь, сэргэх чадвар ангилал зэргийг харгалзан үзэж тоо мэдээлэлд статистикийн боловсруулалт хийж гаргаж ирнэ. Ингэснээр эрүүл бэлчээрээс эрүүл, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэж хэрэглэгчид түүнийг хянах боломжтой болно.

Манай орон өнөөдрийн байдлаар өндөр уул, хангай, хээр, говь хосолсон 112,0 сая га бэлчээрийн талбайтай. энэ бэлчээрийн талбайг 1964 онд 140,0 сая га байсантай харьцуулахад 20,0 хувь буюу 28,0 сая га-аар багасаад байна. Энэ нь бэлчээр үнэгүй нийтийн ашиглалттай, түүхий эдийн нийлүүлэлт хангалттай сайн хөгжөөгүй, хөдөөд ажлын байр хомс зэргээс шалтгаал малчид малын тоо толгойг ихээхэн өсгөж, бүтэц бүрэлдэхүүнд нь бэлчээрт халтай ямаан сүргийн тоо нэмэгдсэнээс бэлчээрийн талбай багассаны дээр түгээмэл талхлагдсан, ургамлын бүрэлдэхүүн цөөрсөн зэргээс шалтгаалж байна.




Швейцарын хөгжлийн агентлаг, Ногоон алт төслийн бэлчээрийн фотомониторингийн 5000 гаруй цэгээс авсан мэдээллээс авсан судалгаагаар Бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан гарсан. Энэ тайлангаар бэлчээрийг 3 үндсэн шалгуур үзүүлэлтээр үр дүнг гаргасан.


1. Зөв ашиглалттай соргог бэлчээр



2. Зохистой ашиглалтыг нэвтрүүлснээр сайжирч буй бэлчээр



3. Доройтож байгаа тул ачааллыг өөрчлөх шаардлагатай бэлчээр




Улсын хэмжээнд 20,6 сая га бэлчээрийн талбай сайжирсан, 29 сая га бэлчээрийн талбай доройтож байгаа буюу ачааллыг өөрчлөх шаардлагатай байна. Эндээс нийт бэлчээр нутгийн 67 хувь доройтсон. Үүний 87 хувь ачааллыг бууруулбал байгалийн аясаараа нөхөн сэргэх чадвараа авч үлдсэн байна гэж үзэж байна.

Бэлчээрийн дээрх шалгуур үзүүлэлтийг байгалийн бүс бүслүүрээр авч үзвэл:


1. Ойт хээрийн бүсийн бэлчээр

4,6 сая га бэлчээр тогтвортой хадгалагдаж үлдсэн, 4,7 сая га бэлчээр сайжирсан, 2,2 сая га тасралтгүй доройтож байна гэсэн дүн харагдаж байна. Эндээс ойт хээрийн бүсэд хэдийгээр хөрсний үржил шимийн хувьд харьцангуй тааламжтай нөхцөл хэдий боловч эрсдэлтэй, тасралтгүй доройтож байгаа бэлчээр тийм бага биш анхаарах хэрэгтэй нь харагдаж байна.



2. Хуурай хээрийн бүсийн бэлчээр.


11,0 сая га бэлчээр тогтвортой хадгалагдаж үлдсэн, 7,7 сая га бэлчээр сайжирсан, 18,9 сая га тасралтгүй доройтож байна гэсэн дүн харагдаж байна. Эндээс бэлчээр хүчтэй доройтож байгаа талбай харьцангуй их байгаа нь харагдаж байна Малын тоо толгойг даацад тохируулах, одоогийн бэлчээрийн аргыг эргэн харах, өөрчлөх хэрэгтэй байна.




3. Цөлөрхөг хээрийн бүс

11,4 сая га бэлчээр тогтвортой хадгалагдаж үлдсэн, 8,0 сая га бэлчээр сайжирсан, 7,8 сая га тасралтгүй доройтож байна гэсэн дүн харагдаж байна. Сайжирсан талбайтай тэнцүү тооны бэлчээрийн талбай тасралтгүй доройтож байна. анхаарах

4. Цөлийн бүсийн бэлчээр





16,5 сая га бэлчээр соргог тогтвортой хадгалагдаж үлдсэн, 8,0 сая га бэлчээр сайжирсан, 0,3 сая га тасралтгүй доройтож байна гэсэн дүн харагдаж байна. Эндээс цөлийн бүс нь харьцангуй тогтвортой соргог бэлчээртэй бүс.

Монгол орны өнөөгийн бэлчээрийн даац, нөхцөлд тохирсон мал сүргийн тоог төрөл, аймаг, сумдаар гаргаж орон нутагт мөрдүүлэх зорилгоор Үндэсний статистикийн хорооноос тооцоо, судалгааг хийсэн байдаг. Энэ судалгаагаар бэлчээрийн нөөц, боломжид үндэслэн тохируулан тооцоолсон мал нь толгойн дүнгээр 51.6 сая толгой гарсан нь одоогийн 2020 онд тоологдсон малаас 30.0 хувь буюу 15.5 сая толгойгоор цөөрөхөөр байна. Бэлчээрийн даацыг 2025 он гэхэд хэвийн ачаалалтай болгохын тулд бүс нутаг бүрийн бод малын тоог хэвийн өсөлттэй хадгалж, хонь ямааны тоог 3-4 хувиар бууруулахаар байна.

Сүүлийн 5 жилийн дунджаар улсын хэмжээнд төл бойжилтийн дүн 19,7-22,7 сая байна. Өнгөрсөн онд 22,3 сая толгой төл бойжуулснаар нийт мал сүргийн тоо 91 сая толгойд хүрсэн байна. Үүнээс 2020-2021 онд 24,6 сая толгой малыг нь эдийн засгийн эргэлтэд оруулсан Үндэсний статистикийн хорооны дүн гарсан байна. Ингэснээр 2020 оны жилийн эцсийн мал тооллогоор 67,1 сая толгой мал тоологджээ. Ийм жишгээр

бэлчээрийн даацад тохируулан жил тутам дунджаар 20,0-23,0 сая шинэ төрсөн төл малыг дараа жилийн мал тооллогын дүнд оруулахгүйгээр намар нь эдийн засгийн эргэлтэнд түргэн оруулж байхаар зохицуулах боломж харагдаж байна. Ингэх нь дараах давуу талуудыг харуулж байна.

- ✓ Малчдад малынхаа үүлдэр угсааг сайжруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлдэг болгох
- ✓ Малчдад төл малд зориулах тэжээл, тарилга, туулгын зардал хэмнэх боломж гарах
- ✓ Малчид чанар сайтай цөөн тооны эх малаа маллаж, өвлийг давах, төл малаасаа түргэн хугацаанд, тогтмол, зардал багатайгаар орлого олох боломж бий болох
- ✓ Тариа туулга огт хийгдээгүй органик хүнс болох хурганы махаар төв суурин газрын хэрэглэгчдийг хангах
- ✓ Малын тоо бус чанарт шилжиж, олон мянган малыг олон жил үр ашиггүй маллаж, бэлчээрээ сүйдэлдэг тогтолцоог өөрчлөх

Өсөж томордоггүй, үржиж олширдоггүй, үр өгөөжгүй малын тоо хэт их болсон явдал юм. Бэлчээр дээр идээшилж байгаа 70 сая малаас жилдээ 2/3 нь буюу багадаа 40 сая төл бойжуулах ёстой. Гэтэл жилд 20 орчим сая төл хүлээн авч байна. Бусад мал нь зүгээр л бэлчээр идээд байж байдаг.

Тэгж байтал нэг зудад үй олноороо хорогдоно. Одоогийнхоор 20 сая төл хүлээн авахад нийт хэрэгцээ нь хангагдаад байгаа юм бол улсын хэмжээнд 40 гаруй сая малтай байхад л хангалттай. Мал, махаа худалдан борлуулж чадна гэсэн итгэл үнэмшилгүй малчид олон тооны эх малыг төллүүлэхээс зайлсхийж сувайруулж байгаа юм. Сүрэг тэр чигээрээ хээлтүүлэгт орохгүй өнжиж байгаа жишээ ч дуулдаж байна. Хэрвээ зах зээлд борлуулах гарц нь нээлтэй байдаг бол малчид сүргийнхээ 2/3-ыг саадгүй төллүүлж дөнгөнө.

Байгаль орчинд үзүүлэх нөлөө, эдийн засгийн үр өгөөжийн асуудлыг ч ярьж эхлэх цаг нь болсон. Нэг ямаанаас 300 грам орчим ноолуур авч байгаа юм, 1 кг ноолуур 100 мянган төгрөг гэж үзвэл 30 мянган төгрөг олохын тулд 1 ямааг 360 хоног бэлчээр идүүлж байна гэсэн үг. Үүнээс гадна эм тариа, өвс тэжээл, нүүдэл суудал гээд малчнаас гарах шууд зардал маш их байгаа. Тэгвэл хонины мах худалдах зах зээлийг төр нээгээд өгчихвөл нэг хонь онд оруулаад 120,000 төгрөгөөр худалдан борлуулахад 4 ямааны ноолууртай тэнцэх орлогыг олох боломж байна. Энэ бол байгаль орчинд ээлтэй, малчиндаа ачаалал багатай боломжийн хувилбар юм. Дүгнээд хэлэхэд мал өсгөх үүргээ малчид хангалтай сайн биелүүлж байна, харин худалдан борлуулах зах зээлийг нь нээж өгөх үүргээ төр маш хангалтгүй биелүүлж байна.

Махны үйлдвэрлэлийн хувьд экспортын нөөц боломж хангалттай байгаа ч экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн байж чадахгүй байна. Экспортод гарахын тулд малчдад “би гадаад зах зээлд гаргах бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа шүү” гэдэг сэдэл, хариуцлага бий болох ёстой. Гэвч махны экспортын өгөөжөөс малчид үр ашиг хүртдэг тогтолцоог бүрдүүлээгүй цагт мах экспортын чиг баримтжаатай бүтээгдэхүүн болж чадахгүй.

Экспортлон гаргахаар бэлтгэж байгаа бүтээгдэхүүний дотоодын зах зээлд худалдахаар бэлтгэж байгаа бүтээгдэхүүнтэй ижил үнэтэй байгаа цагт малчдын хариуцлага дээшлэхгүй.

Мал эмнэлгийн байгууллага малын эрүүл мэндийн мэдээллийн санд хуримтлагдсан баримт нотолгоонд тулгуурлаж худалдааны хорио цээрт халдварт өвчингүй бүс нутгийг

баталгаажуулж нийтэд мэдээлж байх ёстой. Үүнтэй уялдаатайгаар экспортын бүтээгдэхүүн бэлтгэх бүс, нутаг, аймаг, сумыг зааж өгөх хэрэгтэй. Энэ бүсийн малчид малын эрүүл мэндийн асуудлаар илүү үүрэг хариуцлага хүлээж, нүүдлийн мал аж ахуйн зохистой дадлын шаардлагыг хангах, түүхий эд бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоо нэвтрүүлэх зэрэг нэмэлт, тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Улмаар эрүүл бүсээс экспортын мах бэлтгэж байгаа үйлдвэр малчдад дотоодын зах зээлд бэлтгэж байгаагаас өндөр үнэ санал болгох ёстой. Ингэж байж экспортын баримжаатай бүтээгдэхүүн бий болно.

Дэлхийн зах зээлд, ялангуяа ази тивд махны эрэлт буурахгүй. Тиймээс монгол малын махыг багтаах зах зээлийн орон зай хангалтай байгаа гэдэгт итгэлтэй байж болно.

Дэлхийн хүн амын махны хэрэглээ 2030 онд өнөөгийнхөөс 14.0 хувиар өсөх хандлагатай тул төдийлөн нөлөө үзүүлэхгүй болов уу. Тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа энэ хэрэгцээг хангахын тулд янз бүрийн шинэ бүтээгдэхүүн гарч ирж байна. Малын махыг орлуулах бүтээгдэхүүн санал болгох замаар махны хэрэглээг бууруулахыг эрмэлзэж байна гэсэн үг. Дэлхийн хэмжээнд хамгийн бага мах хэрэглэж байгаа улс орны хүмүүс жилд 7-10 кг мах идэж байгаа бол хамгийн их хэрэглээтэй орны хүмүүс жилд 140-150 кг мах идэж байна. Монголчуудын жилийн махны хэрэглээ нэг хүнд 2002 онд 108.8 кг байсан бол одоо 82.1 кг болж буурсан мэдээлэл байдаг. Энэ нь малын махыг орлох хүнсний зүйлийн нэр төрөл нэмэгдэж байгааг харуулж байгаа юм.

Монголын уламжлалт мал аж ахуйн үндсэн үйлдвэрлэл нь мах. Сүү төдийлөн гол нөлөө үзүүлж чадахгүй, харин сүүлийн жилүүдэд ямааны аж ахуйд ноолуурын үйлдвэрлэл томоохон жин дарж байна. Гэхдээ энэ бол байгаль орчинд ээлтэй байдлаар нь үнэлбэл тааруухан үр дүн гарна. Иймээс байгалийн бэлчээрт малладаг монгол малын мах цаашид илүү үнэ цэнтэй бүтээгдэхүүн болох нь гарцаагүй юм.

Бэлчээрийн даацын асуудлыг мөн адил мал, мах нийлүүлэх бүсүүдийг эрүүл бүсүүдийг тодорхой болгосны дараа тухайн бүсүүд дээр бэлчээрийн даацыг тусгайлан тооцож гаргах юм.

2.2.3. Малын эрүүл мэнд, махны чанар, стандартын судалгаа

Малын эрүүл мэнд, махны чанар, эрүүл ахуйн судалгаа

Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батласан бөгөөд уг хөтөлбөрийн зорилго нь Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэх зорилготой.

Тухайн хөтөлбөрийн хүрээнд:

1. Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах;
2. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;

3. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;
4. Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг
5. дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
6. Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж байна.

Мөн Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн түүхийг мөрдөн мөшгөх тогтолцоог бий болгох зорилгоор олон улсын шаардлагад нийцсэн, вэбэд суурилсан мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч гар утасны аппликейшн ашиглан малчин өрхийн хотноос мэдээлэл оруулах боломжтой системийг нэвтрүүлсэн. Энэхүү системийг нэвтрүүлсэнээр:

- Мал эмнэлгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх тарилга, малын шилжилт хөдөлгөөн зэрэг тухайн малын төрсөн үеээс хойших мэдээллийг бүртгэн авч мал, малын гаралтай бараа, түүхий эдийн гарал үүсэл, ариун цэвэр, эрүүл ахуйг баталгаажуулан хүнсний аюулгүй байдлыг хангах,
- Мал эмнэлгийн урьчилан сэргийлэх арга хэмжээг малчин өрх нэг бүрээр цахимаар төлөвлөх, малчны хотонд хүргэж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг хянах, гүйцэтгэлд хяналт тавих.
- Мал, амьтны элдэв өвчний гаралтын мэдээллийг бүртгэж, архив үүсгэн өвчний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллийн сан дээр тулгуурлан худалдааны хорио цээрт халдварт өвчингүй бүсийг тогтоон баталгаажуулах давуу тал үүссэн.

Энэхүү системийг мал эмнэлгийн салбарын үйл ажиллагаанд ашигласнаас хойш 2020 оны 12 дугаар сарын 31 хүртэл 21 аймаг, Улаанбаатар хотын малчид, худалдаа эрхлэгчдэд 535953 цахим гэрчилгээ олгожээ.

Амьд малд малын бүртгэлийн болон эрүүл мэндийн гэрчилгээг, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ олгодог.

Мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянадаг.

- халдварт өвчингүй, тайван бүс, нутагт маллаж байсан эсэх;
- халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай дархлаажуулалтад хамрагдсан эсэх;
- тухайн мал, амьтанд халдварт өвчний ерөнхий болон өвөрмөц шинж тэмдэг илэрсэн эсэх;
- хүнсэнд хэрэглэх мал, амьтанд эм хэрэглэснээс хойших хориглох хугацаа өнгөрсөн эсэх;
- ялган тэмдэглэгээ, бүртгэл хийгдсэн эсэх.

Мал эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лаборатори

Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг, түүхий эд бүтээгдэхүүнд ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг хийх, эрүүл мэнд, гарал үүслийг тодорхойлох, магадлан шинжилгээ хийж бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тогтоох, лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ олгох болон мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлснийг баталгаажуулахад лабораторийн оролцоо зайлшгүй шаардлагатай.


Монгол улсад УМЭАЦийн төв лаборатори, аймгийн сүлжээ лабораториуд орон нутгийн мал эмнэлэг үржлийн газар болон лабораторийн чиглэлээр 22 аймаг, 330 сум, 9 дүүрэгт нийт 800 орчим аж ахуй нэгж дээрх үйл ажиллагаа явуулдаг.

Сумын мал эмнэлэг ариун цэврийн лаборатори нь дараах оношилгоо шинжилгээг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Сумын мал, амьтанд тохиолдож байгаа халдварт паразиттах, халдваргүй өвчнийг оношлох тандах
- Малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнд мал эмнэлэг ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээ хийж, баталгаажуулах.

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүсийн оношилгоо, шинжилгээний лабораторийг зүүн, хангайн, баруун бүсэд өргөтгөн байгуулж, дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Малын өвчин



Малын халдварт болон гоц халдварт өвчин

Дэгдэлтийн хурд, эдийн засагт үзүүлэх хохирол зэрэг хүчин зүйлээс үзэхэд хамгийн их анхаарах шаардлагатай нь “шүлхий” өвчин бөгөөд сүүлийн үед Монголд хонь, ямааны цэцэг өвчин, 2016 онд анх удаа “PPR (бог малын мялзан өвчин)” зэрэг өмнө гарч байгаагүй халдварт өвчин дэгдсэн.

- **Шүлхий өвчин.** Шүлхий өвчин нь амь насанд хүрэх магадлал өндөр биш хэдий ч халдварлах эрсдэл маш өндөр, богино хугацаанд тархдаг үхэр, усны үхэр, хонь, ямаа, гахай, тэмээ зэрэг салаа туурайтан амьтанд халдварладаг. Халдвар нь амьсгалын замаар голчлон дамжих ба ялгарсан вирус нь усны дусал болон хог хаягдлын хамт дэгдэн тархдаг. Олон улсын худалдааны хорио цээрт өвчин бөгөөд эмчилгээ хийдэггүй шууд устгадаг. Монгол улсын зүүн болон баруун хэсгийн хил орчмоор төвлөрөн гарсан байна.
- **Бог малын мялзан өвчин (Peste des Petits Ruminants, цаашид “PPR”)** нь хонь, ямаа, буга зэрэг бог малын халдварт өвчин. Тархалт хурдан, хүнд өвчин бөгөөд хавьтлын замаар тархдаг. Хил дамжин орж ирдэг бөгөөд 2016 онд Ховд аймаг голчлох баруун бүс нутгаар дэгдэж байсан. Уг өвчин гарсан улс орон заавал мэдээлж хорио цээр тогтоох ёстой гоц халдварт өвчин.
- **Хонины цэцэг өвчин.** Шууд буюу амьсгалын замаар халдварлахаас гадна хорхой, шавжаар дамжин шууд бус замаар халдварлах тохиолдол байдаг. Дэгдэлт хурдан тархацтай, вакцин хүрэлцээгүй байдгаас үндсээр нь устгах хүндрэлтэй. Монгол улсын зүүн аймгуудад дэгдэж байсан.

МЭЕГ-аас ирсэн мэдээлэл дээр зураглал гаргана бичих Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний гаралт

Өнгөрсөн 2017 онд л гэхэд найман аймаг, хоёр дүүрэгт шүлхий гарч 451 удаа хөл хорио тогтоожээ. Малын халдварт болон гоц халдварт өвчин буурахгүй байгаа нь:

- Жилээс жилд хэдэн саяараа өсч байгаа малаа вакцинд бүрэн хамруулж чаддаггүй.
- Малаа бүрэн вакцинжуулах хэмжээний вакцинаа дотооддоо үйлдвэрлэх боломжгүй.
- Импортоор оруулж ирсэн вакцин нь чанарын шаардлага хангадаггүй.
- Ариутгал, халдваргүйжүүлэлт хангалттай хийгддэггүй зэргээс шалтгаалж байна.

Иймээс Мал сүргээ өвчлөлөөс хамгаалахын тулд малчин, мал бүхий этгээдийн дараах шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох хэрэгтэй.

- Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Мал эмнэлгийн байгууллагатай жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж, мал сүргээ малын эмчийн байнгын хяналтад байлгах,
- Мал сүрэгтээ өдөр тутмын хяналт тавих бөгөөд малд өвчний шинж тэмдэг илэрснээс хойш 12 цагийн дотор сумын мал эмнэлийн байгууллагад мэдэгдэх.
- Мал, амьтны хашаа, байрны эрүүл ахуй, ариун цэврийг сахих,
- Малын эмчийн зааварчилгааны дагуу өвөлжөө, хаваржаа болон эрчимжсэн мал аж ахуйн байрны ойр орчимд мал, амьтны сэг зэм, биологийн хаягдал устгах зориулалтын цэг барьж ашиглах,
- Хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж байгаа бэлчээрт гамшгаас бусад тохиолдолд мал хорогдсон бол мал, амьтны сэг зэмийг цуглуулж, устгахын зэрэгцээгээр гэрээт малын эмчээр халдваргүйтгэл хийлгэх,
- Мал, амьтнаа ялган тэмдэглэж, мал, амьтны шилжилт хөдөлгөөний талаар бүртгэл хөтөлж байх,
- Мал, амьтныг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гаргахдаа мал эмнэлгийн улсын байцаагчаас мал эмнэлгийн гэрчилгээ авах,
- Гаднаас худалдан авч байгаа болон сумын нутаг дэвсгэрээс гадна зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцуулаад буцаан авчирч байгаа малыг гэрээт мал эмнэлгийн байгууллагаас зөвлөсний дагуу хорио цээрийн хяналтад байлгасны дараа сүрэгт нийлүүлэх,
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулах,
- Бүс, нутгийн хэмжээнд, эсхүл тухайн аж ахуйн хэмжээнд нэр бүхий гоц халдварт болон зооноз өвчингүй статусыг мал эмнэлгийн байгууллагаас баталгаажуулан гэрчилгээ олгосон бол холбогдох зааврын дагуу жил бүр шинжилгээ хийлгэж тухайн статусыг тогтвортой хадгалж байгаагаа нотлох.
- Мал маллах, түүнийг ашиглах, эдлэх, тээвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Хашаа, байр, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, ариун цэврийн нийтлэг заавар”-ыг дагаж мөрөх.
- Зэрлэг амьтдаас байгалийн голомтот халдварт өвчин халдварлах эрсдэлтэй бэлчээрт малаа хариулгагүй бэлчээхээс зайлсхийх.
- Халдварт өвчин тараах эрсдэл бүхий зэрлэг амьтад хашаа, хороонд нэвтрэхээс хамгаалах.
- Халдварт өвчин дамжуулах эрсдэлтэй шавж, мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

- Малын өвчнийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх замаар тархалтыг богино хугацаанд хязгаарлах, малын эрүүл мэндийн түүхийг мөшгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх.
- Халдварт өвчний сэжиг илэрсэн малд лабораторийн шинжилгээ хийх, өвчтэй малд эмчилгээ хийх хугацаанд тэдгээрийг сүргээс ялган тусгаарлах боломжийг бүрдүүлэх.
- Өвчилсөн, бэртэж гэмтсэн малд зайлшгүй шаардлагаар анхны тусламж үзүүлсэн иргэн тухайн үед хэрэглэсэн эм, бэлдмэлийн нэр, хүчинтэй хугацаа, тун хэмжээний талаарх мэдээллийг малын эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэх.
- Өвчилсөн малын эмчилгээний талаарх тэмдэглэлийн хуулбарыг малын эмчээс авч малын эрүүл мэндийн дэвтэрт хавсаргах.
- Малын эм болон төрөл бүрийн химийн бэлдмэлийн хэрэглээний зохистой дадлыг нэвтрүүлэх замаар зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн эмийн үлдэгдэл агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг байх.
- Зөвшөөрөгдсөн химийн бэлдмэлийг зөвхөн гэрээт мал эмнэлгийн байгууллагаар дамжуулан авч ашиглах.
- Химийн бэлдмэлийг хэрэглэхдээ түүнийг хэрэглэх заавар, тун хэмжээ, зохистой хугацааг хатуу мөрдөх.
- Жоргүй олгох эмийг хэрэглэхдээ гэрээт малын эмчээс заавар зөвлөмж авсан байх.
- Эмчилгээ, үйлчилгээнд жороор олгох эм хэрэглэх бол түүнийг зөвхөн малын эмч болон эрх бүхий этгээдээр хийлгэх.
- Дархлаажуулалт, угаалга, туулга, боловсруулалт зэрэг нэгдсэн арга хэмжээ болон эмийн эмчилгээний дараа хүлээх хугацааг үйлчилгээ үзүүлсэн малын эмч тогтоох бөгөөд уг хугацаа дуусаагүй үед малын мах, сүүг зах зээлд нийлүүлэхээс татгалзах.
- Малчин гэрээт малын эмчийн зөвлөмж зааварчилгаагүйгээр эм, химийн бэлдмэл худалдан авах, зориулалтын бус нөхцөлд хадгалах, малын эмчилгээнд дур мэдэн хэрэглэхээс зайлсхийх. /

Мал эмнэлгийн үйлчилгээ,вакцинжуулалт

Вакцинийг ихэнхдээ өвчлөл гарсаны дараа хариу арга хэмжээ авах маягаар хийдэг бөгөөд вакцинжуулалтыг мал сүрэгт хэсэгчлэн хийдэг, вакцинжуулалтанд хамрагдсан малд 1 удаа л тарилга хийгдэж байна.

Вакцинжуулалтыг гол нь өвчин гарсны дараа хариу арга хэмжээ авах зорилгоор биш (дэгдэлтийн голомтын дотор болон эргэн тойронд) эрсдэл өндөртэй газруудад урьдчилан сэргийлэх зорилгоор (өвчин гарахаас өмнө) хийдэг байх хэрэгтэй. Үүний тулд өвчний дэгдэлт гарах хамгийн их эрсдэлтэй хугацаанаас өмнө вакциныг төлөвлөгөөний дагуу бүрэн тарьж дууссан байхуйц хангалттай хугацааны нөөцтөйгөөр жил бүрийн вакцин худалдан авах ажлыг төлөвлөж, худалдан авах ажлыг явуулж, тарилгыг хийж дуусгадаг байх шаардлагатай.

Хүнсэнд төхөөрөх малд тавих хяналтын төрөл, эрүүл мэндийн шаардлага

Малын эмийн хэрэглээний хяналт	Халдварт, паразиттах өвчний хяналт	Хорио цээрийн хяналт	Зооноз өвчний хяналт
---------------------------------------	---	-----------------------------	-----------------------------

Хэрэглэсэн эм бэлдмэлийн талаарх мэдээллийг цахим бүртгэлийн системд бүртгүүлэх	Сүүлийн 6-12 сарын хугацаанд малын гоц халдварт өвчин оношлогдоогүй	Бэлтгэлийн малыг бэлтгэн нийлүүлэгчийн нутаг дэвсгэр, мал, амьтны гоц халдварт өвчнөөс хамгаалсан аж ахуй болон мал төхөөрөх үйлдвэрийн мал баазад 21-ээс доошгүй хоногийн хугацаанд хорио цээрийн хязгаарлалтад байлгах	Сүүлийн 6-12 сарын хугацаанд халдварт болон зооноз өвчин оношлогдоогүй
Байгалийн болон зохиомлоор бэлтгэсэн даавар, дааврын бодисууд, эмийн зүйлсийн үйлчилгээнд өртөөгүй байна.	Африкийн адууны тахал, африкийн гахайн мялзан, бүх төрлийн халдварт энцефаломиелит сүүлийн 3 жилийн турш гараагүй	Малын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, тусгаарласан, эмчилгээ, устгал, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн арга хэмжээ хэрэгжүүлсэн тухай бүртгэл байх	Боом, дуут хавдар өвчин сүүлийн 20 хоногт гараагүй
Нянгийн эсрэг эм, шимэгчийн эсрэг бэлдмэл, дааврын бэлдмэлийг жорын дагуу олгосноос хойш тэдгээрийн биеэс гадагшлах хугацаа дууссан байх	Адууны халдварт цус багадах, нийлүүлгийн өвчин, хулгана яр, гүүний халдварт метрит өвчин тухайн аж ахуйд сүүлийн 12 сарын хугацаанд гараагүй	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс хамгаалсан аж ахуй болон мал төхөөрөх үйлдвэрт хүлээн авсан бэлтгэлийн мал бүрт гарал үүсэл, эрүүл мэндийн байдлын талаарх бүртгэл хөтлөх.	Малыг төхөөрөхөөс 30 хүртэл хоногийн өмнө төхөөрөх бүх малын 15-аас доошгүй хувьд бруцеллез өвчний тандан шинжилгээ хийхэд эерэг урвалтай мал илрээгүй
Мах, махан бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийг хүлцэх дээд хэмжээг тогтоохдоо Олон улсын хүнсний эрх зүйн комиссын “Хүнсэн дэх малын эмийн үлдэгдэлийн хүлцэх дээд хэмжээ ба эрсдэлийн менежмент СХ/MRL 2-2018” стандартыг баримтлана.	Мал, амьтны шүлхий өвчнөөр сүүлийн 12 сарын турш тайван		Листериоз өвчний тандан шинжилгээг нийт үхрийн 3-аас доошгүй хувьд хийхэд эерэг урвалтай мал илрээгүй
Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.3 дахь заалтыг зөрчсөн аж	Үхрийн мялзан, цээж, цэврүүт амтас, бог малын мялзан сүүлийн 12		Малыг төхөөрөхөөс 30 хүртэл хоногийн өмнө төхөөрөх бүх малын 10-аас доошгүй хувьд боом өвчний тандан

ахуйн нэгж, малчны мал, амьтныг хүнсний хэрэгцээнд бэлтгэхгүй	сарын турш гараагүй		шинжилгээ хийхэд эерэг урвалтай мал илрээгүй
Экспортын зориулалтаар боловсруулсан мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний хувьд үлдэгдэл бодисын нэр төрөл, шинжилгээний аргачлал, хүлцэх дээд хэмжээ, баталгаажилтыг импортлогч талын шаардлагад нийцүүлнэ	Хонь, ямааны цэцэг өвчнөөр тайван		Малыг төхөөрөхөөс 30 хүртэл хоногийн өмнө төхөөрөх бүх гахайн 3-аас доошгүй хувьд иж балнад өвчний тандан шинжилгээ хийхэд эерэг урвалтай гахай илрээгүй
	Шувууны томуу өвчнөөр тайван		Малыг төхөөрөхөөс 30 хүртэл хоногийн өмнө төхөөрөх бүх малын 3-аас доошгүй хувьд сүрьеэ өвчний тандан шинжилгээ хийхэд эерэг урвалтай мал илрээгүй
			Малыг төхөөрөхөөс 30 хүртэл хоногийн өмнө төхөөрөх бүх адууны 20-иос доошгүй хувьд ям өвчний тандан шинжилгээ хийхэд эерэг урвалтай мал илрээгүй
			Малыг төхөөрөхөөс 30 хүртэл хоногийн өмнө төхөөрөх бүх үхрийн 3-аас доошгүй хувьд кампилобактериоз өвчний тандан шинжилгээ хийхэд эерэг урвалтай мал, амьтан илрээгүй

- Бэлтгэлийн малыг Хавсралт А1, А2, А3-г заасан халдварт өвчингүй тайван бүс нутаг, сүргээс бэлтгэх.
- Гэмтэл бэртэлтэй, хээлтэй, төллөөд удаагүй эх мал, сульдаж доройтсон, дундаас доош тарга хүчтэй болон стрессэд орсон малыг төхөөрөхөөс татгалзах.
- Нийтийн хүнсний хэрэгцээнд зориулан мал, амьтан өсгөн үржүүлж байгаа эрчимжсэн мал аж ахуй, малчин өрх, аж ахуйн нэгж нь мал, амьтны халдварт, зооноз өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх хөтөлбөрт мал сүргээ бүрэн хамруулж, эрүүл болохыг баталгаажуулсан байх.
- Үзлэг, шинжилгээгээр эрүүл болох нь тогтоогдсон, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан, гарал үүсэл тодорхой мал эмнэлгийн цахим гэрчилгээтэй байх.

- Мал, амьтнаас хүнд халдварладаг болон хүнсний хордлого үүсгэдэг халдварт өвчний сэжигтэй болон өвчтэй мал, амьтныг хүнсний хэрэгцээнд зориулж төхөөрөхгүй.

Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд MNS 6891 : 2020 –д заасанаар Малын намрын амьдын жин дараах шаардлагыг хангасан байна.

- 4 настай адуу 380 кг ба түүнээс дээш
- 4 настай үхэр 330 кг ба түүнээс дээш
- 4 настай сарлаг 280 кг ба түүнээс дээш
- 4 настай тэмээ 440 кг ба түүнээс дээш
- 3 настай хонь 50 кг ба түүнээс дээш
- 3 настай ямаа 45 кг ба түүнээс дээш
-

Малын махны гулуузны жин дараах шаардлагыг хангасан байна.

- ✓ 2 настай бод малын гулуузны жин 120 кг-аас дээш
- ✓ 2 настай бог малын гулуузны жин 18 кг-аас дээш

Мах бэлтгэл

Махны ач холбогдол, хэрэглээ.

Мах бол монгол хүний өргөн хэрэглээний хүнс юм. Мах хүний бие махбодийн өсөлт, хөгжилт, нөхөн төлжилт, биеийн эсэргүүцлийг сайжруулж, уураг болон өндөр илчлэг бүхий өөх тосоор бие махбодийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Мах нь төгс уургийн эх үүсвэр болохын дээр хүний бие махбодид шаардлагатай уураг, тос, эрдэс бодис, амин дэмийг зохих хэмжээгээр агуулсан үнэт түүхий эд юм Мах нь В-ийн төрлийн аминдэм, төмрөөр баялаг тул бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүдийг төмөр дутлын цус багадалтаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй.

Бэлчээрийн монгол малын мах экологийн цэвэр маханд тооцогддог.

Махны найрлага, шинж чанар.

	Махны төрөл	Ус	Уураг	Өөх, тос	Үнс
1	Үхрийн мах	60,12	16,33	22,55	1,0
2	Адууны мах	63,66	20,29	15,16	0,89
3	Ямааны мах	66,45	18,31	13,6	0,61
4	Хонины мах	63,50	16,6	19,1	0,97
5	Тэмээний мах	60,10	17,89	21,05	0,87
6	Сарлагийн мах	60,6	20,0	18,6	0,8

Үхрийн мах. Үхрийн маханд үл орлогдох амин хүчлийн хэмжээ, тосонд уусдаг аминдэмүүд илүү байна. Үхрийн махыг өвлийн улиралд зонхилон хэрэглэдэг.

Адууны мах. Адууны мах халуун чанартай учир өвлийн эхэнд хэрэглэх нь хүйтнийг ажрахгүй давах үндэс болж өгдөг. Зарим эрхтэн нь эмийн чанартай. Жишээ нь, уушги нь уушгины хатгаа хийгээд ханиадыг, дэлүү нь элдэв яр, бөөрний халууныг номтгодог гэж уламжлалт анагаах ухаанд үздэг ажээ.

Ямааны мах. Ямааны махны уураг хялбар шингэдэг, хүний бие махбодиос шингэнийг хөөх өвөрмөц бүтэцтэй, царцамтгай, сэрүүн чанартай гэж үздэг тул түүнийг зөвхөн дулааны

улиралд хэрэглэх нь илүү тохиромжтой. Ямаа зуны эхэн сард цэцэг, элдэв шимт ургамлаар хооллож ургамлын шимийг биедээ шингээдэг тул мах нь эмчилгээ сувилгааны чанартай.

Хонины мах. Хонины сүүлэнд агуулагддаг Д, С, А, К аминдэмүүд сульдаа, элдэв хордлого, харшил, харааны хөгжилд эерэгээр нөлөөлж цус багадалтаас сэргийлдэг. Хонь нь 80 гаруй төрлийн ургамлаар хооллодог 30 орчим зүйл нь эмийн ургамал байдаг нь судалгаагаар тогтоогдсон.

Тэмээний мах. Тэмээний мах найрлагын хувьд үхрийн махтай төстэй боловч нүүрс ус, чихэрлэгийн зүйл ихтэй учир ходоодонд шингэх нь сайн, сэрүүн чанартай байдаг. Борц хийхэд их тохиромжтой.

Мах бэлтгэл

Мах бэлтгэлийн дийлэнх хувийг үйлдвэрлэлийн бус уламжлалт гар аргаар бэлтгэж стандарт бус тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа нь махны бохирдол, эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангагдахгүй байгаагаас бохирдолтой, өнгө үнэрийн өөрчлөлттэй, өнгөц ялзралтай махнууд зах худалдааны төвүүдээр зарагдаж байгаа нь Мэргэжлийн хяналтын үзлэг шинжилгээгээр илэрдэг. . Иймээс

Мах бэлтгэхэд анхаарах зүйл

- *Малыг аль болох цэвэрхэн төхөөрөх, цус, сэвс, хялгас, шороо, чулуугаар бохирдуулахгүй байх*
- *Дотор эрхтэнг гүйцэд авсан байх*
- *Махыг сэврээх ба хөлдөөхдөө хооронд нь наалдуулахгүй байх*
- *Мал нядлахаас өмнө аль болох тайван байлгах (Цочсон малын булчин чангардаг)*

Махны бохирдлыг 3 ангилдаг

Нянгийн бохирдол:

Ажлын хувцас, багаж хэрэгсэл, ажлын байр болон орчин, сав баглаа боодол гэх мэт зүйлст нян үржих боломжтой. Тэдгээр нян махыг бохирдуулна. Иймээс энэ бүгдийн ариун цэврийг сахиж, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлэх хэрэгтэй.

Химийн бохирдол нь:

- *Малын махан дахь эм, бэлдмэлийн үлдэц*
- *Цэвэрлэгээ ариутгал хийсэн химийн бодисын үлдэгдэл юм.*

Механик бохирдол нь:

- *Чулуу, мод, шил зэрэг гадны зүйл хүнсэнд орох*
- *Хүний үс, хумс унаж холилдох зэрэг болно.*

Мах бэлтгэл, махны чанар, эрүүл аюулгүйн үзүүлэлтийг үнэлэхэд мөрдөж буй стандартууд

№	Стандартын нэршил	Стандартын дугаар	Хамрах хүрээ
---	-------------------	-------------------	--------------

Махны эрүүл ахуйн дадлын дүрэм	MNS CAC RCP 58:2013	Энэхүү зөвлөмж нь мал аж ахуйн үйлдвэрлэлээс эхлээд мал бэлтгэх, түүхий мах үйлдвэрлэх, боловсруулах, жижиглэн худалдаалах цэг хүртэл бүх дамжлагад эрүүл ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэхэд хамаарна.
Мах, махан бүтээгдэхүүн. Эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага	MNS 5023:2001	Дотоод болон гадаад зах зээлд нийлүүлэх зориулалтаар мал нядлах, мах боловсруулах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд мөрдөх бөгөөд мах нядлах, боловсруулах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлагыг тогтоож, мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн аюулгүй байдал, баталгааг хангахад хамаарна
Үхэр, өсвөр үхэр, адууны өрөөл, тал өрөөл, хонь, хурга, ямааны гулууз мах. Техникийн ерөнхий шаардлага	MNS1111:2007	Энэхүү стандартаар үйлдвэрийн аргаар үхэр, өсвөр үхэр, адууны өрөөл, тал өрөөл, хонь, хурга, ямааны гулууз мах бэлтгэх, чанарын хяналт хэрэгжүүлэх, зэрэглэх, баталгаажуулах, хадгалах, тээвэрлэх, шалгаж хүлээж авах шаардлагыг тогтооно.
Үхэр, адууны экспортын зориулалтаар хэсэглэж бэлтгэсэн мах	MNS 3514:1983	Энэ стандарт нь үхэр , адууны махыг экспортын зориулалтаар ангилан хэсэглэж бэлтгэхэд хамаарна.
Мах, махан бүтээгдэхүүн. Үхрийн хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага	MNS2456:2009	Энэ стандарт нь үхрийн махыг үйлдвэрлэх, худалдаалах, нийтийн хоол, экспортын зориулалтаар үйлдвэрийн нөхцөлд хэсэглэх, шулах, ангилах, савлах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна
Мах, махан бүтээгдэхүүн. Хонь, ямааны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага	MNS2457:2009	Энэ стандарт нь хонь, ямааны махыг үйлдвэрлэх, худалдаалах нийтийн хоол, экспортын зориулалтаар үйлдвэрийн нөхцөлд хэсэглэх, шулах, ангилах, савлах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна
Мал нядлах үйлдвэр. Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн (НАССР) тогтолцооны загвар	MNS5998:2009	Энэхүү стандарт нь мал нядлах үйлдвэр, цехэд мал нядлах, маханд чанарын хамгаалалт хийх, хадгалах, тээвэрлэх явцад тавих Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцооны үндсэн зарчим, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамаарна
Адууны ангилан шулж, хэвлэж хөлдөөсөн мах	MNS 3512:1998	

Д/д	Үзүүлэлт	Махны төрөл	Тодорхойлолт
1	Өнгө	Үхрийн мах	Булчингийн эд нь улаанаас- улаан хүрэн, өөхний эд нь цайвар шаргалаас- шаргал өнгөтэй.
		Хонины мах	Булчингийн эд нь улаанаас-улаан ягаан, өөхний эд нь цагаанаас- цайвар шаргал өнгөтэй.
2	Үнэр, амт.	Шинэ мах	Малын төрөлд тохирсон өвөрмөц сайхан, анхилсан исгэлэвтэр үнэртэй
		Хуучивтар мах	Гадаргуу нь исгэлэн өмхий үнэртэй, гүн хэсэгтээ шинэ махны үнэр, амттай
		Хуучин мах	Эдийн гүн хэсэгтээ өмхий үнэр, амттай
3	Гадны байдал	Шинэ мах	Гадаргуу нь хатаж эхэлсэн шинжтэй.
		Хуучивтар мах	Гадаргуу нь их хатсан эсвэл салслаг өнгөр буюу зарим хэсэгтээ хөгцөөр хучигдсан.
		Хуучин мах	Гадаргуу нь ихээр хатсан эсвэл маш чийглэгхөгцөөр хучигдаж шимэгчээр хучигдсан.
4	Биелэг байдал	Шинэ мах	Нягт, уян хатан, эрхий хуруугаар дарахад үүссэн ором нь 1 минутад арилна.
		Хуучивтар мах	Зөөлөн төдий л уян хатан биш, эрхий хуруугаар дарахад үүссэн ором нь удаан бүрэн арилахгүй.
		Хуучин мах	Зөөлөн, улбагар, эрхий хуруугаар дарахад үүссэн ором нь арилахгүй
5	рН	Шинэ мах	5,7-6,2
		Хуучивтар мах	6,3-6,5
		Хуучин мах	6,5 –аас их

Хөлдөөсөн махны хувьд махны гадаргуу нь нилээд бараан өнгөтэй, огтлолын гадаргуу нь бор ягаан өнгөтэй байна. Хөлдүү махыг гэсгээгэд дахин хөлдөөсөн байвал өөхний эдийн өнгө усархаг, цусархаг болж өөрчлөгддөг.

	Эүүл ахуйн үзүүлэлт	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Нянгийн ерөнхий тоо	1 гр-д 10 ⁴ ихгүй.
2	<i>Pseudomonas spp</i>	0,1 гр-д илрэхгүй.
3	<i>Shigella spp</i>	Илрэхгүй
4	<i>Salmonella spp</i>	Илрэхгүй
5	<i>E.Coli</i>	Илрэхгүй
6	<i>S.aureus</i>	1гр-д илрэхгүй
7	<i>Bacillus cereus spp</i>	0,1 гр-д илрэхгүй

8	Clostridium perfringens	Илрэхгүй
9	Хөрөнгө, дрожж	1гр-д илрэхгүй

Дээрх үзүүлэлтүүдээс гадна мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хүнд металлын үлдэгдэл, антибиотикийн үлдэгдэл, цацраг идэвхит бодисын үлдэгдэл зэргээр үнэлдэг.

*Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт тавигдах шаардлага
Мал төхөөрөх, мах бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаа махны чанарт маш их нөлөөлдөг.*

Үйлдвэр нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан байгууллагын тогтоосон шаардлагын дагуу мал, амьтанд үзлэг хийх, мал болон бүтээгдэхүүнээс түүвэр дээж авах, шинжлэх, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий мал эмнэлгийн алба эсхүл ажилтантай, уг ажилтан нь мал эмнэлэг, хорио цэрийн арга хэмжээг хэрэгжүүлэх дүрэмтэй байх бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

- ✓ *Орон нутгаас мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх үед мал эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийх, хорио цэрийн арга хэмжээг хэрэгжүүлэх;*
- ✓ *Орон нутгаас бэлтгэсэн малыг үйлдвэрийн мал баазад хүлээн авах, үзлэг, шинжилгээ хийх, хорио цэрийн арга хэмжээг хэрэгжүүлэх;*
- ✓ *Мал, амьтныг үйлдвэрт төхөөрөх үед төхөөрөхийн өмнөх болон дараах мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шинжилгээ хийх, эрхтэн, гулуузад үнэлгээ өгөх.*
- ✓ *Мал эмнэлгийн алба нь мал эмнэлгийн нэгдсэн цахим системд нэвтрэх эрх авсан байх бөгөөд шаардлагатай бүртгэл, мэдээллийг холбогдох газарт тогтоосон хугацаанд мэдээлж, архивын нэгж үүсгэн хадгалах*

Үйлдвэр нь орон тооны малын эмч ажиллуулах боломжгүй бол сум, дүүрэг дэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нартай гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.

Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн ажиллагсад нь шинээр ажилд орохын өмнө сүрьеэ, арьсны халдварт өвчний үзлэг, цээжний рентген зураг, хамар залгиурын арчдас, нян тээгч, цагаан хорхой илрүүлэх шинжилгээнд бүрэн хамрагдаж, эрүүл болох нь тогтоогдсон байна. Цаашид 6 сар тутамд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.

Мах, махан бүтээгдэхүүний дотоодын худалдаанд тавигдах шаардлага

Мах, махан бүтээгдэхүүнийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.2-т заасны дагуу тохирлын үнэлгээнд заавал хамруулна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хангасан, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.19-4.1.21- д зохистой дадлыг нэвтрүүлсэн үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч байгууллагын бүтээгдэхүүнийг худалдааны газар хүлээн авах, зах зээлд нийлүүлэх, нийтийн хүнсний хэрэгцээнд худалдаална.

Мах, махан бүтээгдэхүүн худалдаалах худалдааны газар нь худалдааны зохистой дадал нэвтрүүлсэн байна.

Худалдааны газар стандарт, техникийн зохицуулалт, холбогдох бусад шаардлагад нийцсэн тухай тохирлын гэрчилгээ, гарал үүслийн тодорхойлолт, эрх бүхий байгууллагын сорилт, шинжилгээний дүгнэлттэй, мэдрэхүйн эрхтэний үнэлгээгээр шаардлага хангасан, хадгалах хугацаа дуусаагүй мах, махан бүтээгдэхүүнийг нийтийн хүнсний хэрэгцээнд худалдаална.

Мал төхөөрөх үйлдвэрийн технологийн дагуу үйлдвэрлэсэн шинэ махыг мал эмнэлгийн нэгдсэн цахим системээр лабораторийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээтэйгээр худалдааны газар хүлээн авч шууд хэрэглэгчид хүргэнэ

Махны төрөлжсөн зах, худалдааны төв нь түүхий махыг үйлдвэрлэгчийн дагалдуулсан шинжилгээний дүн, мал эмнэлгийн гэрчилгээг үндэслэн худалдаална. Маханд эмийн үлдэгдэл илрүүлэх /антибиотик/, хими, нян судлалын үзүүлэлт тодорхойлох шинжилгээг зөвхөн итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораториор хийлгэнэ.

Гарал үүсэл нь тодорхойгүй, мал эмнэлгийн гэрчилгээгүй, хөндлөнгийн лабораториор шинжилгээ хийлгээгүй махыг нийтийн хэрэгцээнд худалдаалахыг хориглоно.

Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн

экспортлоход тавигдах хяналт

Монгол улсын хувьд эрх бүхий байгууллага болох МХЕГ, МЭЕГ мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ экспортлох үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтээр тэдгээрийн үйл ажиллагаанд нь хянан магадлагаа хийж тухайн үйлдвэр, аж ахуйн нэгжид бүтээгдэхүүнээ экспортлох тухай зөвшөөрөл олгодог.

Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох сонирхол бүхий үйлдвэр аж ахуйн нэгжүүд Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт (МХЕГ) энэ тухай хүсэлтээ гаргах бөгөөд хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг МХЕГ шалгалтын хэсэг томилон дараах хяналтын хуудсаар шалгана. Эдгээр нь:

- Мах эхлэн боловсруулах үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас,
- Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг шалгах хяналтын хуудас,
- Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас,
- Махны хадгалалтын нөхцөлийг шалгах хяналтын хуудас,
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас,
- Махны үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас.

Хяналтын хуудас нь хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зорилгоос гадна хууль тогтоомж, стандартыг аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах, хяналтын хуудсыг хяналт шалгалт хийхээс өмнө бизнес эрхлэгчдэд урьдчилан хүргэснээр дотооддоо зөрчлөө илрүүлж засах боломжийг олгодог.

Өндөр хөгжилтэй орнууд гадаадаас малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн импортлохдоо мал, амьтны гарал үүсэл нь тодорхой байх шаардлага тавьдгаас гадна хүнд металл, цацраг идэвхт бодис, антибиотик, ургамлын хөнөөлт хортон шавьж, мал амьтны шимэгчдийн эсрэг хэрэглэж буй бэлдмэлийн үлдэгдлийг хянах тогтолцоо бүрдсэн эсэхийг анхаардаг.


Малын эрүүл мэндийн асуудал дээр цаашид өвчлөлтэй бүсүүдийг тодорхойлсны дараа мал, мах нийлүүлэх боломжтой эрүүл бүсүүдийг тодорхойлон гаргах.

2.3. Монгол улсын мах үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Малын гаралтай түүхий эдийн зах зээл нь нэг талаас цаг уурын байдлаас шууд хамааралтай үйлдвэрлэгдэж, харьцангуй тогтвортой хэрэглээнд суурилан явагддаг зах зээл юм.

Ялангуяа манай улс нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг учраас мал, мах бэлтгэл нь улирлын шинж чанартай хийгддэг онцлогтой.

МАХ БЭЛТГЭЛ, МЯН.ТН



1-р график. Эх сурвалж: ХХААХҮЯ

Махны салбарт 2020 онд нядалгааны жингээр 744.5 мян.тн махыг хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн байна. Бэлтгэсэн махны хэмжээг өмнөх онтой харьцуулахад нядалгааны жингээр 199.5 мян.тн-оор нэмэгдэхэд, хонь, ямааны мах 85.0 мян.тн, үхрийн мах 43.8 мян.тн-оор тус тус өссөн байна.

ҮЙЛДВЭРИЙН АРГААР БОЛОВСРУУЛСАН МАХ /МЯН.ТН/



2020 оны үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээг 2019 онтой харьцуулахад 7.1 мянган тн буюу 21.5 хувиар буурсан, 2015 онтой харьцуулахад 13.0 мянган тн буюу 49.6 хувиар нэмэгдсэн байна.


Дотоодын үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал нь зах зээлд нийлүүлэгдэж байгаа нийт махыг боловсруулах боломжтой боловч түүхий эдийн нийлүүлэлт, эргэлтийн хөрөнгө, улирлын байдлаас шалтгаалан хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй байна. Статистик мэдээллээс үзэхэд мал нядлах, мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадлын ашиглалт 14.1%-тай байдаг ба нийт махны 25-30%-ийг үхрийн, 35-40%-ийг хонины, 10-15%-ийг ямааны, 15-20 орчим хувийг адууны мах эзэлдэг.

Зах зээлийн үйлдвэрлэлийн бүтцийг авч үзвэл 80-90 хувь нь уламжлалт хөдөө аж ахуйн аргаар, үлдсэн 10 хүрэхгүй хувь нь үйлдвэрийн аргаар бэлтгэгдэж байгааг /1-р график, 2-р график/-аас харж болно.

Махны экспорт /мян.тн/

Төрөл	2016	2017	2018	2019	2020
Адууны мах	7,984	26,119	32,201	30,835	17,568
Үхрийн мах	695	600	1,055	-	-
Хонь. ямааны мах	238	2,602	6,131	7,042	1,802
Дулааны аргаар боловсруулсан мах нийт			29,300	18,421	20,581
	10,933	31,337	70,705	58,317	41,971

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээ



3-р график. Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээ

2.4. Мал аж ахуйн салбарын бодлого, хууль эрх зүйн орчин

2.4.1. МАА-н салбарын 2020-2025 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилт

Мал аж ахуйн салбарт бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх, мэргэжлийн үйлчилгээг төгөлдөршүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Хөгжлийн загвар нь уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурингийн орчимд бүсчилэн хөгжүүлэх, нөөцийг тогтвортой, зохистой ашиглах, ногоон эдийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна.

Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ:

- Малын төрөл бүрийн тэжээлийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлж, түүний шимт чанарыг сайжруулах үйл ажиллагааг тогтворжуулах;
- Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, эрүүл тайван байдлыг баталгаажуулах арга хэмжээг бүс нутгийн онцлогтой уялдуулан ялгавартайгаар хэрэгжүүлж, баруун болон төвийн бүс нутаг дахь вакцинжуулалтыг эрс багасгаж, эрүүлжүүлэх шинжилгээ хийх стратегид шилжих ба малын эмийн үлдэгдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Бүс нутгийн онцлог, ашиг шимийн чиглэлээс хамаарч малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бий болгох;
- Малын үржил селекцийн ажлыг мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналтын дор малын ашиг шимийн чиглэлд нийцүүлэн үржлийн ажлын стратеги төлөвлөгөөний дагуу явуулах;
- Шинээр болон дахин сэргэж байгаа малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуурыг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангах;
- Гоц халдварт зарим өвчнөөр тайван бүсийн статусыг хангах, мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
- Малын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлд үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, малын эм, биобэлдмэлийн бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэх;
- Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд бүртгэлээр дамжуулан хяналт тавьж гарал үүсэл, эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах;
- Бэлчээр, тэжээл, усан хангамжийг зохистой ашиглах, хамгаалах менежментийн нэгдсэн системийг бий болгож, мал аж ахуйг уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай болгох;
- Малаас гаралтай органик түүхий эд бэлтгэлийн хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж экспортын чиг баримжаатай дотоодын үйлдвэрлэлийг дэмжих юм.

Мал аж ахуйн салбарын 2025-2030 оны хөгжлийн хандлага, хүлээх үр дүн:

Мал аж ахуйн салбарын 2030 он хүртэлх хөгжлийн хандлага нь бэлчээрийн мал аж ахуйн өв соёлыг дэлхий нийтэд таниулсан органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урсгалыг бий болгож үнэ цэнийн сүлжээг хөгжүүлсэн, тогтвортой үйлдвэрлэлийг явуулахад бодлого чиглэгдэнэ.

Хүлээх үр дүн:

- Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл одоогийн түвшнээс буурахгүй ба жилд ойролцоогоор 0,5 хувиар нэмэгдэж 2030 оны түвшинд 22,0 орчим хувьд хүрнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлд оруулах нийт хөрөнгө оруулалтын хэмжээ одоогийн түвшнээс 40 орчим хувиар нэмэгдэх ба үндсэн хөрөнгийн жилийн дундаж өсөлт 5.0 хувьд хүрч, ашгийн дундаж түвшин 20- 25,0 орчим хувьд хүргэнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлд мэдлэгийг хэрэглээ болгох чадамжийг бүрдүүлж, судалгаа ба хөгжлийг өргөжүүлснээр “органик үйлдвэрлэл эрхлэгч” болох өрсөлдөөн, урсгал тэлэгдэнэ.
- Малын биологийн нөөцийг бүрэн ашиглахад суурилсан биотехнологийн үйлдвэрлэл өргөжиж, улс орны эдийн засгийн орлогын шинэ эх үүсвэрийг бүрдүүлж эхлэнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөр хөнгөлөлт, техникийн шинэчлэл одоогийн түвшнээс 30 хүртэл хувиар нэмэгдэнэ.
- Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах систем төлөвшиж, олон улсад IPO гаргана.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх ажлын байр төдийлөн буурахгүй хадгалагдах ба хот суурингийн төвлөрөлтөөс зайлсхийж, нийгмийн ая тухтай байдлаа сайжруулан хөдөөд ажиллах сонирхолын нөхцөл бүрдэж, зорилтот зах зээлд чиглэсэн, үр ашигтай “ухаалаг” аж ахуй эрхлэх загварт шилжинэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газар зүйн болон бусад мэдээллийн системийг бүрэн ашиглан холбогдох мэдээллийг өөрсдөө улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд дамжуулах чадавхитай болж, маркетингийн сүлжээний хөгжил, үр ашиг, бүтээмжээр өрсөлдөх болно.
- Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, тэмцэх, зооноз, халдварт зарим өвчнөөс мал сүргийг бүрэн эрүүлжүүлж, гадаад, дотоод зах зээлд малын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүсчлэн бүрдүүлнэ.

- Стратегийн ач холбогдлыг харгалзан мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох систем тодорхой хэмжээнд хадгалагдна.

Мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй эрх зүйн баримт бичиг

Монгол Улсын хуулиуд:

- Хоршооны тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/ хууль
- Малын тоо толгойн албан татврын тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хиллэр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль г.м

Улсын Их Хурлын тогтоолууд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
- Ногоон хөгжлийн бодлого батлах тухай
- Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай
- Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай
- "Ус" үндэсний хөтөлбөр батлах тухай
- "Монгол мал" үндэсний хөтөлбөр
- Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тогтоолууд:

- “Монгол малчин” үндэсний хөтөлбөр батлах тухай /2020 оны 34 дүгээр тогтоол/
- “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр батлах тухай /2018 оны 400 дугаар тогтоол/
- Жагсаалт, журам батлах тухай /Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт/ /2018 оны 266 дугаар тогтоол/
- Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай /2018 оны 225 дугаар тогтоол/
- Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2018 оны 188 дугаар тогтоол/
- Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2018 оны 29/
- “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай /2018 оны 12/
- Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2017 оны 318/
- Малын гоц халдварт өвчингүй, хорио цээрийн тусгаарлагдсан бүс байгуулахтай холбогдуулан зарим арга хэмжээний тухай /2017 оны 284/
- Малын гоц халдварт өвчний нөхцөл байдалтай холбогдуулан зарим арга хэмжээний тухай /2017 оны 257/
- Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай /2017 оны 14/
- “Мах хөтөлбөр” батлах тухай /2015 оны 492/
- Жагсаалтад нэмэлт оруулах тухай /Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын/ /2014 оны 190/
- Цөм сүргийн үржлийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай /2013 оны 420/
- Журам шинэчлэн батлах тухай /“Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”/ /2013 оны 394/
- Малчдын хоршоог хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2013 оны 08/
- Аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай /2012 оны 158/
- Журам батлах тухай /Малын гоц халдварт өвчний онош/ /2008 оны 305/
- Отрын бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай /2007 оны 187/

- Жагсаалт, журам батлах тухай /Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт/ /2003 оны 173/
- Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2002 оны 181/

2021 онд мал аж ахуйн салбарт шинээр боловсруулах эрх зүйн баримт бичгүүд

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичиг.
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- Малын эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- “Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, холбогдох судалгаа;
- Малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөрийн төсөл

2.5. Махны зах зээлд оролцогч талууд, тэдгээрийн оролцоо

Мах нийлүүлэлтийн тогтолцоонд голлон оролцогч тал болох мах үйлдвэрлэгч буюу малчид, махны худалдаа эрхлэгчид болох ченж худалдаачид, махны үйлдвэрүүд болон хэрэглэгчдийг хамруулан ойлгож байгаа юм.

Малчид

Малчид нь махны нийлүүлэлтийн тогтолцоонд бэлтгэн нийлүүлэх талын оролцогч юм. Малчдын өнөөгийн нөхцөл байдлын судалгааг санал асуулгын болон ярилцлагын аргаар Хэнтий аймгийн Баян-Овоо сумын малчдаас авсан бөгөөд судалгааны нэгдсэн дүгнэлт нь малчдын ихэнх буюу 80 орчим хувь нь хүн хүч хүрэлцэхгүйн улмаас малыг амьдаар ченжид борлуулдаг, үлдсэн хувь нь гулуузаар нь зах болон худалдааны төвүүд, хоршоодоор дамжуулан сумын төвийн цэцэрлэг сургуульд нийлүүлдэг байна.

Мах боловсруулах үйлдвэр

2021 оны байдлаар манай улс нь нийт 123 мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэртэй. Үүнээс улсын хэмжээнд махны холбоонд бүртгэлтэй 65 нь мал нядлах цехтэй байна. Байршлын хувьд Улаанбаатар хотод 20, орон нутагт 45 үйлдвэр байдаг бөгөөд үйлдвэрийн нийт хүчин чадлын хэмжээг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар харуулсан байна.

Байршил	№	Үйлдвэрийн нэр	Нядалгааны хүчин чадал /тн, ээлж/		Бэлтгэх махны хэмжээ /тн, ээлж/		Гүн хөлдөөх /тн/	Хөргөлттэй агуулах /тн/
УЛААНБААТАР	1	Мах импэкс ХХК	200	2000	24	36.0	120	16000
	2	Мах маркет ХХК		1000	0	18.0	60	7500
	3	Монгол мах экспо ХХК	200	1000	24	18.0	40	1200
	4	Монгол эко мах ХХК	150	300	18	5.4	10	300
	5	Саян-Уул ХХК	100	300	12	5.4	12	1400
	6	Миста ХХК	100	500	12	9.0	10	400
	7	Цалуут импэкс ХХК	250	800	30	14.4	50	1000
	8	Эрүүл Монгол эко мах ХХК	80	500	9.6	9.0	20	100
	9	Преком ХХК	10		1.2	0.0		10
	10	Язгууртан Эко хүнс ХХК-СХД	80	400	9.6	7.2	10	150
	11	Дун фан интернэйшнл трейд ХХК-СХД	300	600	36	10.8	160	800
	12	Үүлэнгөү ХХК-СХД	180	300	21.6	5.4	10	150
	13	Натурал грийн фүүдс ХХК-СХД	100	210	12	3.8	20	130
	14	Оргилон гүн ХХК-СХД	200	500	24	9.0	50	700
	15	Өргөө мийт трейд ХХК-СХД	800	1400	96	25.2	15	600
	16	Нүүдэлчин Мах маркет ХХК	40	200	4.8	3.6		50
	17	Шилүүст сүмбэр ХХК	130	520	15.6	9.4	32	500
	18	Агро нэгтгэл трейд ХХК	150	500	18	9.0	40	800
	19	Мийт фүүдс ХХК	180	800	21.6	14.4	30	400
	20	Эм Ди Си Пи ХХК	60	500	7.2	9.0	80	500
ДАРХАН-УУЛ	21	Дархан эрдэнэ мах комбинат ХХК	100	500	12	9.0		100
	22	Дархан мийт фүүдс ХХК	350	1500	42	27.0	10	4000
ОРХОН	23	Эрдмийт ХХК	150	500	18	9.0	90	1100
	24	Эрдэнэт мах маркет ХХК	200	600	24	10.8	120	1100
	25	Монгема ХХК	150	500	18	9.0	80	600
	26	Жаргалант мах импэкс ХХК	20	100	2.4	1.8	30	200
ТӨВ	27	Эрдэнэ хүнс ХХК	400	1000	48	18.0	100	500
	28	Зуун мод мах боловсруулах ТӨҮГ	50	100	6	1.8	20	100
	29	Эко фүүдс трейд ХХК		2000		3.6	200	1000
	30	Баяндэлгэр хүнс ХХК	100	200	12	3.6		20
АРХАНГАЙ	31	Хангайн хүнс ХХК	300	500	36	9.0	20	1200
БАЯН-ӨЛГИЙ	32	ЭТ транзит ХХК	150	600	18	10.8	22	1000

	33	Зэргэр интернэшнл ХХК	70	300	8.4	5.4	8	600
	34	Нөхөд ХХК	200	500	24	9.0		100
	35	Угур ХХК	150	500	18	9.0		600
	36	Азат ХХК	200	800	24	14.4	20	600
БАЯНХОНГОР	37	Баянхонгор констракшн ХХК	50	500	6	9.0	4	250
ДОРНОГОВЬ	38	Дорнын говь ХХК	100	300	12	5.4	10	100
ГОВЬ-АЛТАЙ	39	Алтайн сүрлэг нуруу ХХК	100	250	12	4.5		100
	40	Хүрийн овоо ХХК	200	1000	24	18.0		400
ЗАВХАН	41	Завхан хүнс групп ХХК	200	1000	24	18.0	10	2000
	42	Завхан Мах маркет ХХК	100		12		32	300
	43	ЭДГС ххк	50	300	6			200
	44	Тэс шим хоршоо	80	300	9.6	5.4	10	150
ХЭНТИЙ	45	Өгөөмөр мал нядалгааны газар	50	500	6	9.0		100
	46	“Таван эрдэнэ” ХХК	30	200	3.6	3.6		100
	47	Мах экспорт ХХК	100	400	12	7.2	40	500
	48	Мон мийт ХХК	50	350	6	6.3	40	250
ХӨВСГӨЛ	49	Хөвсгөл мах маркет ХХК	200	400	24	7.2		1000
	50	Уудам – Хангай ХХК	50	500	6	9.0		250
	51	Дуут улаан ХХК	30	200	3.6	3.6		200
ХОВД	52	Баруун монгол интернэшнл ХХК	100	300	12	5.4	20	500
	53	Жаргалант шанд ХХК	100	500	12	9.0	5	500
	54	Людида ХХК	80	250	9.6	4.5		70
СЭЛЭНГЭ	55	Гацуурт компанийн үйлдвэр	80		9.6	0.0	20	200
	56	ОНӨУҮГ мал нядалгааны цех	10	30	1.2	0.5		120
СҮХБААТАР	57	Сүхбаатар мах маркет ХХК	100	800	12	14.4	20	1000
	58	Нэмэр их ХХК	80	200	9.6	3.6		200
УВС	59	Бумномин ХХК	200	500	24	9.0	20	500
	60	Монтува ХХК	200	500	24	9.0	20	500
	61	Увс мах маркет ХХК	80	400	9.6	7.2	20	150
БУЛГАН	62	Булган мах маркет ХХК	100	500	12	9.0	15	500
ӨВӨРХАНГАЙ	63	Өв эко мийт ХХК	200	1000	24	18.0	350	1000
	64	Далай одод ХХК Орхон түшээ махны үйлдвэр	100	500	12	9.0	20	500
	65	Дээжийн өргөө ХХК	80	300	9.6	5.4	100	400
Нийт хүчин чадал			8800	34510	1056	583.4	2245	57550

Махны холбоо болон махны үйлдвэрүүдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, ярилцлагын аргаар дараах дүгнэлтийг гаргав.

Тулгамдаж буй асуудал:

1. БНХАУ-руу 6 сарын 15-ны өдрөөс хойш мах экспортонд гарахгүй байгаа. Мөн 2022 оны 2 сард БНХАУ-д өвлийн олимп болох гэж байгаатай холбогдуулан энэ жилдээ бол БНХАУ-руу гарах экспорт бараг байхгүй гэж ойлгож байна. Иймд хэзээ хилээр гарах нь тодорхой бус махыг бэлтгэх экспортын компани байхгүй байна.
2. Дотоодын нөөцийн махны хувьд 17 компани 13,000 тн мах бэлтгэх хүсэлт ирүүлсэн байсан. Үүнтэй холбогдуулан яамнаас банкуудруу үйлдвэрүүдийн 3 хувийн зээлийн материалыг явуулсан боловч тэдгээрийн хүсч буй зээлийн хэмжээ банкнаас багасч шийдвэрлэгдэж байгаа асуудал тулгарч байгаа. Зарим компаниудад зээл гараагүй, одоогийн байдлаар 12,000-13,000 тн мах нөөцлөх боломжтой байна.
3. Махны үнэ өндөр байна. Энэ нь дараах шалтгаантай гэж харж байна:
 - Малчид малаа зарах дургүй байна. Үүний шалтгаан ЗГ-с олгож байгаа 3 хувийн зээлийг олон малчин авсан байна. Иймд малчдын мөнгөний хэрэгцээ багассан.
 - Зуншлага сайхан болсон тул малчдын зүгээс өвөл өнтэй болно гэсэн таамаг байгаа тул малчид малаа зарах хүсэлгүй байна.
 - Ковидоос болж өнгөрсөн жилүүдэд малчдын хүүхдүүдийн сургалтын төлбөрийн дарамт бага байсан тул малчдын мөнгөний хэрэгцээ багассан. 11-12 сараас л малчид хөдөлгөөнд орж махны үнэ буурах боловч гэж таамаглаж байна.
 - Өмнө нь 20,000 төгрөгөөр малчид мал, мах зарах талбай түрээслэж зогсоод малаа зараад явдаг байсан тул одоо хяналт чангарсан. Нэг талаас зөв шаардлага боловч махны үнэ өсөхөд бага боловч нөлөөлж байна.
4. Зээл авч нөөцийн мах бэлтгэж байгаа компаниудын хувьд махны үнэ чухал байдаг тул махны үнэ өндөр байх эрсдэл тулгарч байна. 2018 онд 70,400 тн мах экспортонд гарсанаар малчдын амьдрал эрс сайжирсан, өмнө нь хаан банкинд малаа барьцаалан зээл авсан олон малчин байснаас өр зээлээс гарах боломж бүрдсэн. (Экспортонд мах гаргах нь ач холбогдолтой гэдгийг үүнээс харж болно.) 2019 онд 56,300 тн гарсан нь бас бага тоо биш. 2020 онд 38,000 тн мах гарсан. 2021 оны эхний хагас жил 25,000 тн мах гарсан. Хүмүүс экспортод мах их гарснаар махны үнэ дотооддоо өсдөг гэсэн ташаа ойлголттой байдаг.
5. Нийт экспортын 50 орчим хувийг адууны мах эзэлдэг тул одоогийн нөхцөл байдалд адууны үнэ буурсан, адуу зарах хүсэлтэй иргэд их байгаа боловч авах үйлдвэр байхгүй байна.
6. Малын өвчин гарсан. Үхрийн махны арьс товруудах гэх хүнд халдах аюултай шинэ төрлийн өвчин, шүлхий зэрэг 4 төрлийн өвчин гарсан. Үүнтэй холбогдуулан түүхий үхрийн мах тодорхойгүй хугацаагаар импортлох боломжгүй талаар БНХАУ болон Оросоос бичиг ирсэн.

Нийлүүлэлтийн дэд бүтэц

МАХ БЭЛТГЭЛ БОЛОН ТҮҮНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ


Монгол Улсын мах бэлтгэлийн тогтолцооны өнөөгийн байдал

2021 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотод малын бойны 20 цэг байгаагаас

Эмээлт төв-15

Багануур дүүрэгт-1

Налайх дүүрэгт-4 тус үйл ажиллагаа явуулж дараах толгой мал бойлж нийслэлийн хэрэгцээг хангаж байна.



Улсын хэмжээнд мал бойлох үйл ажиллагааны 80% нь гар аргаар 20% нь үйлдвэрийн аргаар бэлтгэж байгаа. Орон нутаг дахь хоршоод болон түүхий эд бэлтгэгч/ченж/ малчдаас малыг бэлэн мөнгөөр худалдаж авч өөрсдийн нядалгааны байранд нядлаж махаа тээвэрлэж авчрах, эсвэл нийслэл рүү амьдаар нь тээвэрлэн авчирч нийлүүлэх замаар мал, махны мах нийлүүлэлт явагддаг.

Мал, амьд амьтан тээвэрлэхэд Монгол Улсын стандарт-MNS 6688 : 2017 шаардлага хангаж тээвэрлэх ба тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь урьдчилан тухайн тээврийн хэрэгслийг урьдчилан тээвэрлэх тэвш болон дугуйнд ариутгал хийгдсэн, мал эмнэлгийн гарал үүслийн тодорхойлолттой байна. Гарал үүслийн тодорхойлолт нь вакцин, тарилга, туулгад хамрагдсан-эрүүл бүсийн мал, мах/-г нотлоно.

Амьд мал, махны тээвэрлэх үнэ /төгрөгөөр/

<i>Тээвэрлэх үнэ /км-ээр/</i>	<i>1000 хүртэл км дотор</i>	<i>1000с дээш км зайтай</i>
Бод /толгой/	50,000	52,000-53,000
Бог /толгой/	10,000	12,000-13,000
Мах /тн/	120,0-130,000	130,000-140,000

МАЛ ТЭЭВЭРЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ

Бэлтгэлийн малтай харьцах

Бэлтгэлийн малыг тууварлах, тээвэрлэхэд тавих шаардлага:

- Мал тууварлах, тээвэрлэх үеийн мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлага, тавлаг байдлын шаардлагыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- Бэлтгэлийн малыг тээвэрлэхээс 24 цагаас багагүй хугацааны өмнө нэг дор хашиж, услаж тэжээсэн байна.

Бэлтгэлийн малыг автомашинаар тээвэрлэхэд дараах шаардлагыг хангана:

- Зориулалтын нэг тээврийн хэрэгсэлд бодыг наснаас хамаарч 1,7-2,0 м² хүртэлх талбайд 1 толгой, бог малыг наснаас хамаарч 0,7-0,9 м² талбайд 1 толгой, гахайг наснаас хамаарч 0,6-0,8 м² талбайд 1 толгой байхаар тооцож босож зогсох, хэвтэхэд хангалттай орон зайг ханган тээвэрлэнэ.
- Мал зогсоо байх үед бүхээг болон дээврийн хэсэгт хүрэхгүй, агаар чөлөөтэй нэвтрэх зайтай байна.
- Харин шувууг агааржуулалт чөлөөтэй нэвтрэх зай завсар бүхий хайрцагт тээвэрлэнэ.
- Малыг хооронд нь шахцалдуулахгүйн тулд тасалгаалж тээвэрлэнэ.
- Бодыг нэг тасалгаанд 10-аас ихгүй, богийг нэг тасалгаанд 30-аас ихгүй толгойгоор тээвэрлэх ба бодыг давхарлаж ачих тохиолдолд 2 давхраас илүүгүй, богийг 3 давхраас илүүгүй байлгана.
- Давхарлаж ачихад бодын тасалгааны шал таазны хоорондын өндөр 1,9 метрээс багагүй, богийн тасалгааны шал таазны хоорондын өндөр 1,3 метрээс багагүй байна.
- Суурингийн гаднах хатуу хучилттай зам дээр 50 км/цагаас ихгүй, ердийн хөрсөн зам дээр 40 км/цагаас илүүгүй хурдтай явна.
- Тээвэрлэлтийн явцад 8-10 цаг тутамд малыг 1 цагаас доошгүй хугацаанд амраан услах ба шаардлагатай бол тэжээнэ. Малыг тасралтгүй тээвэрлэх хугацаа 10 цагаас илүүгүй байна.
- Өөр хоорондоо бэртэл, гэмтэл учруулахаас сэргийлж, тавлаг байдлыг хангаж, мал, амьтныг төрлөөр нь тусгаарлан тээвэрлэнэ. Хүлж, тушиж, баглаж, муужруулж болон хэвтүүлэн даруулж тээвэрлэхгүй.
- Мал, амьтныг дулааны улиралд хэт хурц нартай үед өдрийн цагаар тээвэрлэхээс зайлсхийж өглөө, орой, шөнийн цагаар тээвэрлэнэ. Хүйтний улиралд мал, амьтан осгох, хөлдөхөөс сэргийлсэн байна.
- Мал, амьтныг үйлдвэрт авчирч буулгах бүрт тээврийн хэрэгсэл, торон хашлагыг аль болох богино хугацаанд цэвэрлэж, шаардлагатай тохиолдолд халдваргүйтгэнэ.

Мал, амьтан тээвэрлэх тээврийн хэрэгсэл дараах шаардлагыг хангасан байна:

- Мал амьтныг хялбар ачиж буулгах боломжтой, тээвэрлэлтийн үед мал үсрэх, харайх, унах, хөхрөх, шархдах, бэртэх, гэмтэхээс сэргийлсэн бүтэц зохион байгуулалт, хэлбэр хийцтэй байна.
- Тээвэрлэлтийн явцад мал хэт халах, хөрөх, салхи, бороонд өртөхөөс хамгаалсан бүтээцтэй байна.
- Тээвэрлэлтийн явцад мал амьсгалын дутагдалд орох, яндангийн утаанд хордохоос сэргийлсэн агааржуулалтын бүтээцтэй байна.
- Тээврийн хэрэгслийн шалны түвшинд агаарын урсгал чөлөөтэй сэлгэн шингэн хаягдлаас ялгарах үнэрийг хөөх зохион байгуулалттай байна.
- Хальтардаггүй сараалжин шалтай, хаягдал шингэн, ялгадасны сувагтай, ялгадас, шавхайгаар бохирдохоос сэргийлэх хашлагатай байна.

- Мал ачих тээврийн хэрэгслийн чиргүүл нь нэгээс илүү тавцантай тохиолдолд мал хэт олноороо шахалдах, бохирдохоос сэргийлсэн тусгаарлагч хана, хашлага, хаалгатай байна.
- Мал тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь яаралтай үед болон ослын үед мал буулгах хаалга, хашлагатай байна.

Төмөр замаар мал, амьтан тээвэрлэх үед дараах шаардлагыг хангана:

- Дөрвөн тэнхлэгтэй галт тэргэнд нас гүйцсэн үхэр 16-24 толгой, ♣ өсвөр үхэр 24-28 толгой; ♣ Хонь, ямаа 80-110 толгой; ♣ Гахай амьдын жин 80 кг хүртэл бол 50-60 толгой, 81-100 кг бол 44-50 толгой, 101-150 кг бол 28-44 толгой, 150 кг-аас дээш жинтэй бол 20-28 толгой; ♣ Адуу 14 толгойгоос илүүгүй;
- Дулааны улиралд ачих гахайн тоог 10-15 хувиар цөөлөх бөгөөд хэт тарган буюу бордсон гахайг дөрвөн тэнхлэгт вагоноор тээвэрлэхгүй.
- Дулааны улиралд хаалганы сараалжин цонхыг нээх ба хүйтний улиралд сараалжин цонх, салхивч, нүхийг хаана.
- Нэг галт тэргэнд өөр өөр төрлийн мал тээвэрлэхгүй, тээвэрлэж буй малыг нас, хүйс, биеийн жингээр нь ангилж тээвэрлэнэ.
- Мал, амьтдыг ачиж буулгахдаа тусгай шат ашиглах ба хэт чанга дуу чимээ гаргахгүй, зодож зандрахгүйгээр тайван энэрэнгүй байдлаар гүйцэтгэнэ.
- Тээвэрлэх үед малын бууц, шивхийг тогтмол зайлуулна.
- Тээвэрлэлтийн явцад мал, амьтан өвчлөх тохиолдолд малын эмч хяналтад авч, тусгаарлан эмчилгээ арчилгааг хийх ба өвчтэй мал, амьтдыг малын эмчийн зөвшөөрөлгүйгээр замд буулгаж, орхихгүй.

Төмөр замаар тээвэрлэх мал, амьтны тэжээлийн шаардлага:

- Төмөр замаар тээвэрлэх мал, амьтныг өдөрт хоёр удаа тэжээх ба тэжээхийн өмнө хүйтний улиралд өдөрт 2 удаа, дулааны улиралд өдөрт 3 удаа услана.
- Үхэрт 4,5 кг, хонь, ямаанд 3,5 кг өвс, гахайнд 2.5 кг хүчит тэжээл өгнө.
- Мал, амьтан тээвэрлэх төмөр замын чингэлгийн хананд тэжээлийн болон усалгааны онгоцыг эвхэгддэг байдлаар суурилуулсан байна

Малыг тууварлах үед дараах шаардлагыг хангана:

- Малыг тууварт гаргахын өмнө боом, цэцэг, дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, бруцеллез, сүрьеэ, ям өвчнийг оношлох шинжилгээ хийсэн байна.
- Нэг суурьт хонь, ямаа 500-1000 толгой, үхэр 150-200 толгойгоос хэтрээгүй байна. Эр, эм малыг хольж суурилахгүй.
- Малыг тууварлах явцад орон нутгийн болон өөр суурийн малтай нийлүүлэх болон хольж солихгүй.
- Ширүүн бороо, шороон болон цасан шуургатай үед тууварлалтыг түр зогсооно.
- Тууварлалтын эхний 2-3 өдөрт үхрийг 10 км, хонь, ямааг 6-8 км-ээс хэтрүүлэлгүй тууварлаж дасгах ба цаашид үхрийг өдөрт 10-15 км, хонь, ямааг 8-12 км зайд тууварлана.
- Тууварлалтыг 5-7 өдөр үргэлжлүүлсний дараа ус, хужир, өвс ургамал тохиромжтой нутагт 1-2 өдөр амраана.
- Адууг өдөрт 15-20 км-ээс холгүй тууварлах ба 1-2 удаа ханатал нь усалж, хужирлана.
- Тууврын замд 20-25 км тутамд мал хужирлах цэг байгуулах ба бог малд хоногт 10-15 г, бод малд 30-40 г хужир ноогдохоор тооцоолон нөөцөлсөн байн
- Дамжин өнгөрч байгаа сумын нутаг дэвсгэрт мал тууварлах маршрутын дагуу тууварлаж, хоноглохыг зөвшөөрсөн газар хоноглоно.

Төхөөрөх малыг амраах, сойх:

- Үйлдвэр нь мал бэлтгэх, төхөөрөх, мал, амьтныг хамгаалах, тавлаг байдлыг хангах журам, эсвэл удирдамжтай байна.
- Тээвэрлэж, тууварлаж ирсэн малыг 2-3 хоног амрааж, энэ хугацаанд хангалттай

тэжээж, усална. Энэ үед үргээж цочоох, стрессэд оруулахгүй байх арга хэмжээ авч, тайван байлгах нөхцлийг бүрдүүлсэн байна.

- Малыг 24 цагаас илүү сойх шаардлага гарсан тохиолдолд тэжээл өгөх нөхцөл, боломжийг бүрдүүлж, тэжээлийн нөөц бэлтгэсэн байна.
- Сойх хашаа нь бод мал тутамд 6-7 м² , бог мал тутамд 0,8-1,0 м² , гахайд 1,8-2,0 м² талбай ноогдохоор тооцно.
- Бод малыг 24-48 цаг, бог мал, гахайг 24 цаг сойно. Сойлгын үед малыг цангаахгүй байлгана. Зуны улиралд өдөрт 4 удаа, өвөл 2 удаа усална. Усалгааг төхөөрөхөөс 4 цагийн өмнө зогсооно. Мал сойлгын бүртгэл хөтөлнө.
- Малд төхөөрөхийн өмнөх үзлэгийг мэргэжлийн байгууллагаас баталсан стандарт ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэнэ.

Дүгнэлт

Улсын хэмжээнд мал бойлох үйл ажиллагааны 80% нь гар аргаар, 20% нь үйлдвэрийн аргаар бэлтгэж байна.

Гар аргаар бэлтгэж байгаа махыг ченжүүд стандарт, ариун цэврийн шаардлага хангахгүйгээр хээр бойлж, хэрэглэгчдэд хүргэж байна.

Харин үйлдвэрүүдийн хувьд шаардлага, стандартын дагуу бойлж, бэлтгэн нийлүүлдэг, татвар хураамжаас зугтах боломжгүй зэргээс шалтгаалан ченжүүдтэй харьцуулахад зардал харьцангуй өндөр, ялгаатай байна.

Иймд үйлдвэрүүд ченжүүдийн малчдаас авч байгаа үнээс өндөр үнээр авах боломжгүй тул малчдын ихэнх нь шууд ченжүүдэд амьдаар малаа борлуулж байгаа нь том асуудал үүсгэж байна гэж үзэж болохоор байна.

Махны үйлдвэрээс ченжүүд илүү их ашигтай ажиллаж байгаа харагддаг. Үйлдвэрүүд холбогдох татвар, хураамж төлж үйл ажиллагаа явуулдаг бол Ченж ямар ч татвар, хураамж төлдөггүй. Энэ нь махны үйлдвэрийн хөгжилд сөрөг нөлөөтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МАХНЫ ЭКСПОРТ, ГАДААДЫН БИРЖИЙН СУДАЛГАА


3.1 Махны экспортын судалгаа

Мах импортлогч орнуудын судалгаа, тавигдах шаардлага, зүй тогтол, стандартад нийцүүлэх боломж;

3.1.1 БНХАУ УЛС РУУ МАХ ЭКСПОРТЛОХ

Дэлхийн банкны судалгаагаар Хятад улсын махны хэрэглээ сүүлийн 30 жилийн хугацаанд нийтдээ дөрөв дахин нэмэгдсэнийг мэдэгджээ. Хятадын хүн ам махны тэжээллэг чанарыг чухалчилдаг учраас **үхэр** ба **хонины махыг** ил хэрэглэхийг зорьдог.

Зураг 1. 2010-2019 оны хоорондох Хятадулсын хүн амын нэг хүнд ногдох махных эрэгзлээ/кг-



аар/

БНХАУ-Д АДУУНЫ МАХ ЭКСПОРТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ

МОНГОЛЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ

- Мал эмнэлэг, хорио цээрийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
- Мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (экспортын гэрчилгээ), шаардлагатай бичиг баримт (МХЕГ)
- Гарал үүслийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МУХАУТ)
- Итгэмжлэлийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МХЕГ)
- Тохирлын гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (СХЗГ)
- Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл, шаардлагатай бичиг баримт (ХХААХҮЯ)
- Гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримт (ГЕГ)

БНХАУ-ЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ

Экспортлогчоор бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

- Компанийн талаарх мэдээлэл
- Өргөдлийн маягт бөглөсөн байх
- Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ гэх мэт
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)

БНХАУ-ын Гаалийн байгууллагад шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

- Төлбөрийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
- Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ)
- Ачааны манифест

БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох

БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ МОНГОЛЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ

- Мал эмнэлэг, хорио цээрийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
- Мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (экспортын гэрчилгээ), шаардлагатай бичиг баримт (МХЕГ)
- Гарал үүслийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МҮХАҮТ)
- Итгэмжлэлийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МХЕГ)
- Тохирлын гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (СХЗГ)
- Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл, шаардлагатай бичиг баримт (ХХААХҮЯ)
- Гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримт (ГЕГ)

БНХАУ-ЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ


Экспортлогчоор бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

- Компанийн талаарх мэдээлэл
- Өргөдлийн маягт бөглөсөн байх
- Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ гэх мэт
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)

БНХАУ-ын Гаалийн байгууллагад шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

- Төлбөрийн нэхэмжлэх
- Сав баглаа боодлын жагсаалт
- Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
- Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл
- Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ)
- Ачааны манифест

ИМПОРТЛОГЧИЙН ГААЛИЙН ПРОЦЕСС



Бүгд Найрамдах Хятад Ард улсын махны зах зээлийн байдал, бирж дээрх арилжааны талаар

Махны зах зээлийн хэв шинж

Бүгд Найрамдах Хятад Ард улс нь 1 тэрбум 4 зуун сая хүн амтай дэлхийн хамгийн том улс юм. Энэ том улс манай улстай хил залгаа оршин байгаа нь нэг талаас дэлхийн хамгийн том зах зээл манай дэргэд байна гэж үзэж болох юм.

2020 оны оны Бүгд Найрамдах Хятад Ард улсын статистик мэдээг харахад махны хэрэглээ 80,76 сая тонн хүрсэн ба үүнээс гахайн мах 56,06 сая тонн, тахианы мах 11,86 сая тонн, үхрийн мах 8,17 сая тонн, хонь ямааны мах 4,67 сая тонныг хэрэглэсэн байна. Харин судлаачдын үзэж байгаагаар 2022 он гэхэд Хятадын нийт махны хэрэглээ 90,31 сая тоннд хүрнэ гэсэн таамаглал байна.

Бүгд Найрамдах Хятад Ард улсын нэг хүнд ноогдох махны хэрэглээ 57,2кг байдаг бөгөөд үхрийн махны жилийн хэрэглээ нь дөнгөж 5,8кг юм байна. Харин манай улсын нэг хүнд ноогдох махны хэрэглээ 83кг гэсэн тооцоо бий. Хятадын гаалын импортын мэдээнээс харвал 2020 онд Хятад улс түүхэндээ хамгийн их үхрийн мах буюу нийт 965,115 тонн үхрийн мах импортлосон байна.

Бүгд Найрамдах Хятад Ард улс нь хот, муж болгондоо малын зах, худалдааны төв байдаг нь онцлогтой. Мөн 2021 оноос Далианы бирж дээр амьд гахайн фьючерсийн арилжаа хийж эхэлсэн нь аливаа үнийн болон махны хомсдолоос хамгаална гэж үзэж байна.

Амьд малын цогцолбор аж ахуй

/Гуанси Хэчи Хуайюан Хунша мал худалдааны жишээн дээр /



2010 онд байгуулагдсан бөгөөд эхний үе шат нь 2,8 га , хоёрдугаар үе шат нь 3,8 га талбайг хамарсан захтай ба 600 га- д үржлийн аж ахуй, газар тариалан, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, мал худалдаалах, худалдан авах , ложистик түгээлт, зах зээлийн борлуулалтад түшиглэсэн үйл ажиллагааг үхэр,гахайн үржүүлэг, тэжээлийн бааз, амьд малын худалдааны захыг ажиллуулдаг байна.



Энэхүү цогцолбор гахай болон үхэр дээр голчлон үржүүлдэг байна. Үйл ажиллагааны хувьд малд хэрэгтэй бүхнийг цогцоор авч хэрэгжүүлждэг байна. Үүнд:

1. Үржил селекцийн ажил
2. Сайн чанарын тэжээл тарих, малыг тэжээх
3. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
4. Амьд малын арилжаа хийх
5. Мах боловсруулах үйлдвэр ажиллуулах
6. Тээвэр ложистикийг шийдэх
 - a. Амьдаар хүргэх
 - b. Нядалсан тохиолдолд сав баглаа боодлыг хийх зэрэг юм

Амьд малын зах / Хойд Хятадын Мал Худалдааны Төв/



Хойд хятадын мал худалдааны төвийн зууч үйлчилгээний газарт өдөр бүр бүртгэлтэй худалдаалагдаж буй малын эзлэх хувийг харбал:

- Үхэр 60 хувь ,
- Адуу 30 хувь,
- Луус, илжиг 10 хувь

Үүлдрийн хувьд симментал, Ангус, Шарол, Пирмонт, Талын улаан бух, Чинчуан үхэр, Хөлөнбэйр Санхэ үхэр, Голштейн үхэр гэх мэт.

Холбогдох газрууд малын худалдааны зах зээлд хатуу хяналт тавьж, үнийн өсөлт, зах зээлийн дэг журмыг алдагдуулж, Үйлдвэрлэлийн болон худалдааны хорио цээрийн үхэр, адуу, тэмээ, луус, илжиг, хонь арилжаалдаг худалдаачдад үнэ төлбөргүй хоол хүнс, байр, агентлагийн унаагаар үйлчилдэг. Худалдан авалт, өндөр чанартай, үр ашигтай үйлчилгээ, хүчтэй сурталчилгаа нь улс орны бүх муж, хотуудын худалдаачдыг зах зээлд нэвтрүүлэхийн тулд татан оруулах хүсэлтэй ирсээр байна. Үүнийг дагаад төлбөр тооцоо болон тээвэр, ложистикийн байгууллагууд

Амьд малын зах / Лунда малын зах /



Үхрийн худалдаагаар дагнан ажилладаг. Өдөрт 2000-3000 толгой үхэр арилждаг байна. Дуудлага худалдааны аргаар худалдааг явуулдаг. Үйл ажиллагааны хувьд:

1. Хашаа түрээслэдэг.
2. Худалдан авагчаас 35-70 юаний хураамж авах



Зах нь тээврийн асуудлыг шийдснээрээ давуу талтай байдаг байна.

Дүгнэлт

Дэлхийн махны хэрэглээ жилд 2% -иар нэмэгсэн ба өсөлтийн тэн хагас нь Хятадын хүн амын махны хэрэглээтэй шууд холбоотой ба махны хэрэглээний 80 хувь үхэр, гахай ,


үүний 88 хувь гахайн мах эзэлж байна. Тиймдээ ч Хятадын муж, хот болгонд хэрэглэгчдэд илүү ойр, хүндрэл бэрхшээлгүйгээр худалдан авалт хийх боломжийг бүрдүүлэхийн амьд махын худалдаа, захыг ажиллуулж байна. Захын хувьд өөр, өөрийн онцлогтой ба үүнд малын төрөл, том жижгээсээ шалтгаалан түрээсийн төлбөр, татвар хураамж өөр өөр байдаг байна.

3.1.2 ОХУ-РУУ МАХ ЭКСПОРТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ

№	Баримт бичгийн нэр	Олгох байгууллага	Тайлбар
1	Адууны мах бүтээгдэхүүн экспортлох квот	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Экспортлогч аж ахуйн нэгжид бүтээгдэхүүн экспортлох квот олгоно. Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, Мал эмнэлгийн гэрчилгээ олгох тухай албан бичиг олгоно.
2	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	Мал эмнэлгийн ерөнхий газар	“Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ” олгоно. Экспортлогч ОХУ-аас өөр улсад мах, махан бүтээгдэхүүн гаргах бол Оросын холбооны улсын хөдөө аж ахуйн хяналтын албанд (Россельхознадзор) энэ тухай албан тоот илгээнэ.
3	Мал эмнэлгийн гэрчилгээ Форма № 26	МХЕГ-ын Экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын газар	Экспортын бүтээгдэхүүнд “Мал эмнэлгийн гэрчилгээ” (Форма № 26) олгож, экспортын ачилтын гаалийн бүрдүүлэлт дуусах үед энэ гэрээнд тамга дарна, гарын үсэг зурна, хилийн боомт дахь хяналтын албанд “Экспортын мэдэгдэл” бичнэ.
4	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн ерөнхий газар	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг барааны дагалдах баримт бичгийн хамт баталгаажуулна
5	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газар	Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгоно.
6	Бүтээгдэхүүний дээжинд мал эмнэлэг ариун цэврийн шалгуур үзүүлэлтүүдээр шинжилгээ хийж дүгнэлт гаргана.	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори	Шинжилгээний дүгнэлтийг үндэслэн МХЕГ экспортын бүтээгдэхүүнд Мал эмнэлгийн гэрчилгээ олгох, эс олгох асуудлыг шийдвэрлэнэ

	Баримт бичгийн нэр	Олгох байгууллага	Тайлбар
1	Адууны махны импортын зөвшөөрөл (Разрешение на ввоз)	Оросын холбооны улсын хөдөө аж ахуйн хяналтын алба (Россельхознадзор)- наас олгоно)	Энэ зөвшөөрлийг импортлогч тал өөрийн орон нутаг дахь хөдөө аж ахуйн хяналтын албанаас авч экспортлогч талд илгээнэ. Энэхүү зөвшөөрлийг аваагүй тохиолдолд барааг ОХУ-ын хилээр нэвтрүүлэхгүй.
2	Тохирлын деклараци(Декларация о соответствии)	Оросын холбооны улсын эрх бүхий байгууллагаас олгоно	Оросын холбооны улсын тохирлын деклараци олгох эрх бүхий байгууллагаас импортлох бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрт 1-3 жилийн хугацаагаар олгоно. Энэ гэрчилгээ байхгүй бол тухайн бүтээгдэхүүнийг ОХУ-ын зах зээлд борлуулж болохгүй
3	Автомашинаар бараа тээвэрлэх урьдчилсан мэдээлэл /Предварительная информация для перевозок автотранспортом	Бараа импортлох үед хилийн боомт дахь холбооны гаалийн албанаас олгоно.	Импортлогч энэ мэдээллийг авсны тээвэрлэгчид мэдэгдэх ба үүний дараа тээврийн хэрэгсэл ОХУ-ын хилийн боомт руу орох эртэй болно. Тээвэрлэгч нь энэ мэдэгдлийг цаасаар аваагүй мэдэгдлийн дугаарыг импортлогч талаас авч хилийн шалганы ажилтанд хэлж болно.
4	Гаалийн мэдүүлэг	Холбооны гаалийн алба (Федеральная таможенная служба),	Тухайн экспортын ачилттай холбоотой бүх мэдээлэл болон бичиг баримтуудыг ОХУ-ын гаалийн цахим мэдээллийн санд урьдчилан 3-5 хоногийн өмнө мэдүүлж, бэлтгэл ажлыг хийх
7	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ (FORM A) олгоно.	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь импортлогч талын хувьд гаалийн татвараас 25%-ийн хөнгөлөлт эдлэх үндсэн баримт болно
8	Олон улсын ачаа тээврийн падаан CMP	Тээвэрлэгч байгууллага	Олон улсын ачаа тээврийн падаан нь улс хоорондын тээвэр хийх үндсэн баримт болно
9	Төлбөрийн нэхэмжлэл, сав баглаа боодлын цуваа		Экспортлогч аж ахуйн нэгж

ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД АДУУНЫ МАХ ЭКСПОРТЛОХОД ШААРДЛАГАТАЙ ГЭРЧИЛГЭЭ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ҮЙЛ ЯВЦ, ДЭС ДАРААЛЛЫН ЗУРАГЛАЛ



3.2 Амьд малын арилжаа

Турк улсын махны зах зээлийн байдал, бирж дээрх арилжааны талаар

Махны зах зээлийн хэв шинж

Турк улсад 2020 оны тооллогоор 18.2 сая бод мал бүхий 72.27 сая мал тоологдсон бөгөөд бод малын дийлэнх хувийг үхэр эзэлж, харин бог малын дийлэнх хувийг хонь эзэлдэг байна. Турк улсын газарзүйн байршил, онцлог нь мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйл ажиллагаа эрхлэхэд таатай орчинг бүрдүүлдэг гэж үздэг. Тус улсад нэг хүний жилд хэрэглэх махны хэмжээ Монгол улсаас 2-3 дахин бага буюу 2019 онд 48 кг байсан бол энэ тоо 2020 онд 28 кг болжээ. Үүнийг цар тахалтай холбоотойгоор иргэдийн амжиргааны түвшин буурсантай холбон тайлбарладаг байна.

Мах бэлтгэн нийлүүлэх тогтолцоонд дараах олон оролцогч талууд байдаг. Үүнд:

- Мал бүхий иргэн, ААН-үүд
- Орон нутгийн мал нядалгааны газрууд
- Мах болон загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, сүү болон сүүн бүтээгдэхүүний холбоо, махны холбоо
- Хувийн хэвшлийн мах нядалгааны цэгүүд
- Махан бүтээгдэхүүн үйлвэрлэгч аж ахуйн нэгжүүд, хувийн хэвшлийн байгууллагууд
- Амьд мал, махны арилжааг явуулах Таваарын биржүүд
- Амьд малын зах, махны лангуу, сүлжээ дэлгүүрүүд

2011 онд батлагдсан "Малын худалдааны тусгай зөвшөөрөл олгох, амьд малын худалдааг зохион байгуулах" тухай журамд зааснаар зөвхөн тусгай зөвшөөрөл авсны үндсэнд амьд малын худалдааны үйл ажиллагаа эрхлэх бөгөөд 2017 оны байдлаар нийт 114 тусгай зөвшөөрөлтэй малын зах, 15 амьд малын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй таваарын бирж бүхий нийт 129 гаруй мал худалдаалах цэг байдаг байна.

Мах нядалгааны цэгүүдийн хувьд тус оны байдлаар төрийн мэдэлд 425 мал нядалгааны цэг, хувийн хэвшлийн 210 мал нядалгааны цэг, нийт 635 мах нядалгах цэг үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр мах нядалгааны цэгүүдэд бэлтгэгдсэн мах нь махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд, бөөний болон жижиглэнгийн махны лангуунд хүргэгдэх, мөн түүнчлэн экспортонд гардаг байна.

Турк улсын амьд мал, махны экспорт нь Азербайжан, Сири, Иран, Ирак зэрэг Зүүн болон Ойрхи Дорнодын орнуудад гардаг бөгөөд 2020 онд 2,6 сая долларын махны экспорт, 26,9 сая долларын импорт хийгдсэн байна. (Эх сурвалж: Турк улсын статистикийн хороо, 2020 он).

Биржээрх амьд мал, махны арилжаа

Турк даяар 113 таваарын бирж байдаг бөгөөд тус улсад таваарын биржүүдийн үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалт удирдлагыг хариуцагч байгууллага нь Туркийн худалдааны танхим, таваарын биржүүдийн холбоо (The Union of chambers and commodity exchanges of Turkey) байна. Тус холбооны идэвхтэй үйл ажиллагааны хүрээнд таваарын биржүүд нэгдсэн мэдээллийн системд холбоотой биржүүд дээрх бүртгэгдсэн арилжааны

үнийн мэдээлэл бусад биржүүд дээр тэр даруй чөлөөтэй шилжиж, мэдээлэх боломжийг хангасан байна. Эдгээрээс 15 нь амьд малын арилжааг зохион байгуулдаг байна. Арилжаалах хамгийн доод хэмжээний хувьд тухайн биржээс шалтгаалан бод малын мах 30-100 кг, бог малын мах 30-100 кг, харин амьд малын доод хэмжээг заагаагүй байдаг нь жирийн иргэд ч өрхийн хэрэгцээгээ биржийн арилжаанаас хангах боломжтойг харуулж байгаа юм.

Зах зээлийн бодит үнэ тогтоох, малын хулгай буюу бүртгэлгүй худалдаанаас урьдчилан сэргийлэх, амьд малын тээвэрлэлтэд хяналт тавих, малын худалдааны далд эдийн засгийг ил болгох, мөн малын эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэх зэрэг хэрэгцээ шаардлагын хүрээнд амьд малын арилжааг Таваарын биржүүд зохион байгуулж эхэлсэн байдаг. Биржийн зүгээс ямар нэгэн үнэ тогтоодоггүй бөгөөд зөвхөн худалдагч болон худалдан авагч талуудын хооронд хийгдсэн арилжааны үнийг олон нийтэд түгээх үүргийг Бирж хүлээдэг.

Турк улсад Таваарын биржүүд амьд малын арилжааг дараах 2 аргаар зохион байгуулдаг.

- Уламжлалт малын захын үйл ажиллагаа буюу энэ нь түгээмэл нэвтэрсэн арга байна.
- Дуудлага худалдаа хэлбэрээр малын арилжааг зохион байгуулах (онцгой гойд шимт бод малыг дуудлага худалдаанд оруулдаг)

Ихэнх биржүүд уламжлалт малын захын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнд малын эмчийн үзлэг, ариутгал халдваргүйжүүлэлт, малын тэжээл, малын хорогдох байр, баталгаат жин, малыг худалдан авагч талд шилжүүлэх бүртгэл, худалдагч болон худалдан авагч талын ая тухыг хангасан танхим, ариун цэврийн өрөө, интернет зэрэг үйлчилгээнүүд багтдаг байна.

Малын арилжаанд худалдагч талд дараах шаардлага тавигдана:

- Гарал үүслийн гэрчилгээ
- Чихний ээмэг

Мал болгон улсын мал бүртгэлийн цахим санд бүртгэлтэй бөгөөд гэрчилгээний дугаар бүхий ээмэгтэй байна. Гэрчилгээний дугаараар малын бүртгэлийн сангаас тухайн малын вакцинд хамрагдсан эсэх, нас хүйс г.м мэдээлэл авах боломжтой байдаг.

- Мал эмнэлгийн бичиг

Биржийн амьд малын арилжааны давуу талууд:

- Бүртгэлтэй малын арилжаа явагдана
- Эрүүл мэндийн үзлэг хийгдсэн мал авах боломжоор худалдан авагчдыг хангана
- Ямар нэгэн асуудал гарахад Биржээс хэнээс ямар төрлийн мал авсан гэх мэт бүртгэлийн мэдээлэл гардаг, эрүүл мэндийн үзлэг Биржийн зүгээс хийгддэг тул үнэн зөв байдлыг Бирж хариуцна.
- Биржээр дамжуулан борлуулалт хийсэн тохиолдолд 1 хувийн орлогын татварыг суутгуулна. (Энэ нь биржээр дамжаагүй тохиолдолд хувьд 2 хувь байдаг)

- Мал бүхий иргэдэд үүсэх давуу тал: интернет, ариун цэврийн өрөө, малын тэжээл унд, харуул хамгаалалт, арилжааны цаг дуусахад малаа үлдээж дараагийн өдөр малаа худалдаалах боломжтой г.м.

Малын захын үйл ажиллагаа

Малын зах 3 хэсгээс бүрддэг:


- Мал хүлээн авах хэсэг
- Малын хүлээлгийн хэсэг
- Малыг худалдаалах хэсэг

Зарим биржүүдэд эдгээр 3 хэсэг нь хоорондоо **S** хэлбэрээр холбогдсон байна. Мөн ямар нэгэн асуудал гарахад малыг тусгаарлах хэсэгтэй байна. Хүлээн авах болон хүлээлгийн хашаануудад малын тэжээл, ус байрлана.

Малыг худалдагч тал Биржийн малын арилжаа явагдах захаас хашаа түрээслэж авна. Тодорхой хэмжээний түрээсийн төлбөр, малын тэжээлийн төлбөр, арилжаа хийгдвэл арилжааны шимтгэл зэргийг төлөх үүргийг хүлээнэ. Цөөн мал авчирсан иргэн нийтийн хашаанд бага түрээс төлж малаа борлуулах боломжтой. Малын хашаанууд бод, бог малын хувьд тусдаа байна.



Малын худалдаа хэрхэн явагддаг вэ?



Малын эмчийн үзлэг хийгдэж малын мэдээллийн санд үзлэгийн мэдээллийг оруулна. (хээлтэй эсэх, нас бие гүйцсэн эсэх г.м)

Малын худалдаа явагдаж худалдагч болон худалдан авагч тал үнэ хөлсөн дээр тохиролцож чадвал өөрт хамгийн ойр Биржийн ажилтанд мэдэгдэж арилжааг биржид бүртгүүлнэ. Төлбөр тооцоо хийгдэж малын мэдээллийн санд малыг эзэмшигчээр худалдан авагч талыг бүртгэснээр арилжаа дуусгавар болно.

Тээвэр, нядалгаа

Худалдан авагч тал малыг амьдаар тээвэрлэн авч явах эсвэл зарим биржийн хувьд хувийн компанийн нядалгааны цэгтэй байдаг тул иргэд малаа нядлуулах боломжтой.

Тээврийн үйлчилгээ үзүүлэгч иргэн ААН-үүд биржид бүртгүүлж үйлчилгээ үзүүлдэг.

Хэн нэгэн хүн мал худалдаж аваад дараа нь малын эрүүл мэндийн эсвэл бусад асуудал гарахад малыг хэнээс авсан, ямар төрлийн мал авсан талаарх мэдээлэл (чихний ээмэг), ямар байгууллагаар тээвэрлэлт хийгдсэн гэх зэрэг мэдээлэл Биржид бүртгэлтэй үлддэг тул шийдвэрлэхэд хялбар байна. Мөн бүрэн камержуулалт хийгдсэн байдаг тул шүүлгэн харах боломжтой.

Малын дуудлага худалдааны үйл ажиллагаа

Зарим биржүүд бод малын дуудлага худалдаа зохион байгуулдаг. Худалдаалах малын хувьд тавигдах шаардлагын хувьд амьд малын арилжаатай ижил байна. (Хугацааны хувьд сийрэг зохион байгуулдаг ж.нь: 7 хоногт 1 удаа)

Зураг 1 Kirklareli таваарын биржийн амьд малын дуудлага худалдааны танхим



Зураг 2 Дуудлага худалдааны үйл явц



Дуудлага худалдааг онцгой гойд шимт бод малын хувьд зохион байгуулдаг бөгөөд худалдан авагч талд биржид гишүүнээр элссэн байх шаардлага тавигдаж олон тооны худалдан авагчид үнэ хаялцах аргаар ялагчийг тодруулдаг.

Дүгнэлт

Турк улсын хувьд амьд мал, махны арилжааг биржээр зохион байгуулахад худалдагч тал татварын хөнгөлөлт эдлэх боломжтой (хуулиар 2 хувийн орлогын татвар төлдөг бол биржийн арилжаанд орсноор 1 хувийн татвар төлнө) бөгөөд энэ нь арилжааны шимтгэл болох 0,1 хувиас их тул худалдагч талд ашигтай байх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Мөн мал бүхий иргэд, худалдан авагч талуудыг цэвэр ая тухтай орчинд үйлчлүүлэх боломжоор хангах, малын харуул хамгаалалт, тэжээлээр хангах, баталгаат жин, талуудын бичиг цаасны ажлыг хөнгөвчлөх, малын шилжилт хөдөлгөөнийг малын бүртгэлийн системд хийх, малын эрүүл мэндийн үзлэгийг мэргэжлийн хүмүүс хийх гэх зэрэг давуу талууд Биржийг сонгох шалгаан болж байна гэж үзэж байна.

3. Нэгдсэн дүгнэлт

Махны нийлүүлэлтийн одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, шат дамжлагыг бууруулах, сүлжээг боловсронгуй болгох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр гарцыг тодорхойлох, цаашид биржийн арилжаанд оруулахад боломжит хувилбараар санал дэвшүүлэх судалгааны хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Манай улс зах зээлд шижих 1990 оноос өмнө мал, махыг тогтсон нэг системээр төвлөрүүлэн үйлдвэрт нийлүүлж байсан байна. Энэ нь төлөвлөгөөт эдийн засагтай, өмчийн нэг хэлбэр ноёрхож байсан учир тухайн үедээ уг систем хэрэгжих бүрэн боломжтой байсан байна.
2. Зах зээлд шилжиж эхэлсэн 1990 оноос хойших үед өмч задарч, өмчийн олон хэлбэр бий болсон үед мах бэлтгэн нийлүүлэлтийн хуучин систем тохирохоо больсон байна. Үүнтэй уялдаад төрийн ямар нэг зохицуулалтгүйгээр ченж гэдэг сайн дураараа түүхий эд цуглуулан нийлүүлдэг бүтэц бий болсон байна.
3. Дээрх харьцуулсан судалгааны материалаас үзэхэд ченжүүдээр дамжуулан малчдаас мал, махыг цуглуулан үйлдвэр болон зах зээлд нийлүүлж байгаа одоогийн хэлбэр нь олон сул талтай байгаа учраас мах бэлтгэн нийлүүлдэг одоогийн системийг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.
4. Зах зээлийн үед мал, махыг бэлтгэн нийлүүлдэг сонгодог загварыг бий болгож уг салбарт нэвтрүүлэх хэрэгтэй байгаатай уялдан биржээр дамжуулан арилжааг зохион байгуулан, нэвтрүүлэх;
5. Биржийн арилжааг нэвтрүүлэхтэй холбогдуулан хөнгөн дэд бүтэц ялангуяа агуулахын аж ахуйг зөв байршуулан хөгжүүлэх, малыг гарал үүслийн гэрчилгээтэй болгох, хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэх нь чухал байна. Иймд малын гарал үүслийг тодорхойлох чиглэлээр цаашид мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг сумдын хөдөө аж ахуйн газартай нягт хамтран ажиллах шаардлагатай байна. Мөн агуулах, хоршоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ХХААХҮЯ-тай хамтран ажиллах, төрийн бодлоготой уялдуудан хөгжүүлэх;
6. Мөн хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэх чиглэлээр бирж дэмжлэг үзүүлэн ажиллаж, чадварлаг байнгын бус хоршоодын тоог нэмэгдүүлэх замаар мал, махны арилжааг зохион байгуулах;
7. Хэрэв биржээр дамжуулан мах бэлтгэн нийлүүлдэг систем хэрэгжиж үйл ажиллагаа нь тогтворжвол экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан үйлвэрүүдийг арижаанд оролцуулах;
8. Биржийн арилжааг зохион байгуулахдаа агуулах, тээвэрлэлтийн дэд бүтэц хөгжөөгүй, мал, мах нь онцгой нөхцөл байдал шаарддаг зэргийг үндэслэн, дотоодын үйлдвэрүүдийг арилжаанд түлхүү оруулах;
9. Биржийн мал, махны арилжааг төрийн худалдан авалт, амьд мал болон гулуузаар арилжих арилжаагаар эхлүүлэх;
10. Байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг бууруулах, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх асуудлыг харгалзан үзэж хонийг амьдаар болон гулуузаар арилжих арилжааг зохион байгуулах;
11. Амьд малын арилжааг зохион байгуулахдаа олон улсын туршлагыг харгалзан үзэж дуудлага худалдааны хэлбэрээр зохион байгуулах нь оновчтой хэлбэр байж болох юм гэсэн дүгнэлтүүдийг өгч байна.